

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ШИЛЖИЛТ
БОЛОН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУДАЛГАА

(ТАТВАРЫН ТОГТОЛЦООГ БЭЖҮҮЛЭХ НЬ II ШАТ)

ЭЦСИЙН ТАЙЛАН

JICA LIBRARY



J1166603[9]

2001 оны 7сар

ТӨСӨВ САНХҮҮГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

S S F

J R

01-107

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ**

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ШИЛЖИЛТ
БОЛОН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУДАЛГАА**

(ТАТВАРЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ II ШАТ)

ЭЦСИЙН ТАЙЛАН

2001 оны 7сар

ТӨСӨВ САНХҮҮГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

Товчилсон үг

ТЕХ: Татварын ерөнхий хууль
ТМНБ: Татварын мэргэшсэн нягтлан бодох
ТИНБ: Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодох
НӨАТ: Нэмэгдсэн өртгийн албан татвар

Валютын ханш

(2001 оны 7 сарын байдлаар)

1.00 USD / 1,096₮
1.00 USD / 125.40иен



1166603[9]

Өмнөх үг

Япон улсын засгийн газар Монгол улсын засгийн газрын хүсэлтээр тус улсын татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх судалгааны ажлыг явуулахаар шийдвэрлэсний дагуу Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагаас Монголын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих судалгааны нэг хэсэг болгон уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг 2000 оны 7-р сараас 2001 оны 7 сар хүртэл Санхүүгийн судалгааны институтийн Кояанаги Юүжиро ахлагчтай судалгааны хэсгийг Монголд томилон ажиллууллаа. Мөн Хитоцубаши Их сургуулийн олон улсын үйлдвэрийн газруудын стратегийн судалгааны тэнхимын профессор Асанума Шинжи тэргүүтэй хяналтын зөвлөлийг байгуулан уг судалгааны ажилд мэргэжлийн болон арга зүйн талаас хяналт тавьж ажиллалаа.

Судалгааны хэсэг нь Монгол улсын Засгийн газар болон Үндэсний татварын ерөнхий газрын холбогдох хүмүүстэй зөвлөлдөн санал солилцохын зэрэгцээ газар дээр нь болон өөрийн оронд судалгаа, шинжилгээний ажил хийсний үндсэн дээр энэхүү тайланг боловсрууллаа.

Энэхүү тайлан нь Монгол улсад татварын зохистой, эрх тэгш тогтолцоог бүрдүүлэх болон татварын тогтвортой орлогыг хангахад хувь нэмэр болохын хамт манай хоёр улсын найрамдлыг хөгжүүлэх үйлсэд нэг алхам болно гэдэгт найдаж байна.

Эцэст нь судалгааны ажилд хамтран ажиллаж туслалцаа үзүүлсэн бүх хүмүүст чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

2001 оны 8 сар

Японы Олон Улсын Хамтын
Ажиллагааны Агентлагийн
Ерөнхийлөгч
Сайто Күнихико

Илгээлт

Японы Олон Улсын Хамтын
Ажиллагааны Агентлагийн Ерөнхийлөгч
Сайто Күнихико Танаа

Монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих судалгааны нэг хэсэг болох татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх судалгааны ажлын II шатны тайланг өргөн барьж байна.

Энэхүү тайланд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагтай байгуулсан гэрээний дагуу Төсөв санхүүгийн судалгааны институтээс хийсэн судалгааны үр дүнг нэгтгэн гаргасан болно.

Уг судалгааны ажлын хүрээнд судалгааны хэсэг 2000 оны 7 сараас 2001 оны 7 сар хүртэлх хугацаанд 7 удаа Монгол улсад очиж ажиллан судалгаа явууллаа. Газар дээр нь хийсэн судалгааны ажил болон Японд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн талаар Үндэсний татварын ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудтай зөвлөлдөн санал солилцсоны дүнд Монгол улсын татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх санал зөвлөмжийг боловсруулж гаргалаа. Судалгааны хэсэг уг санал зөвлөмж дээр үндэслэн татварын ажилтнуудад зориулсан сургалт семинар зохион явуулах, гарын авлага боловсруулах зэргээр тодорхой арга зүйн удирдлагаар хангах ажлыг хийж гүйцэтгэн, уг тайланг боловсрууллаа.

Судалгааны хэсгээс Монгол улсын татварын тогтолцоог бэхжүүлэх нь Монгол улсын цаашдын хөгжилд зайлшгүй шаардлагатай зүйл гэж үзсэний үндсэн дээр Монгол улсын Засгийн газарт энэ чиглэлд тэргүүлэх ач холбогдол өгөхийг санал болголоо.

Судалгааны ажлыг явуулахад хамтран ажиллаж туслалцаа үзүүлж Монголд байх хугацаанд халуун дотноор хүлээн авсан Монгол улсын Засгийн газар болон Үндэсний Татварын Ерөнхий Газарт чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Мөн Японы Олон Улсын Хамтын ажиллагааны Агентлаг, Гадаад Явдлын Яам, Монгол улс дахь Япон Улсын ЭСЯ, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газарт үнэтэй санал зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлсэнд гүн талархал илэрхийлье.

2001 оны 8 сар

Монгол улсын зах зээлийн эдийн засагт
шилжих шилжилтийг дэмжих
судалгааны хэсгийн ахлагч
Кояанаги Юүжиро

Гарчиг

Товч хураангуй

I хэсэг Удиртгал

1. Судалгааны зорилго, үр дүн
 - 1.1 Судалгааны зорилго
 - 1.2 Судалгааны үр дүн
2. Тайлангийн агуулга
3. Судалгааны бүтэц, зохион байгуулалт
4. Өргөн барих тайлан

II хэсэг Татварын систем

- Бүлэг 1 Санхүү болон татварын системийн өнөөгийн байдал
- 1.1 Төсөв санхүүгийн байдал болон татварын бодлого
 - 1.2 Өнөөгийн татварын тогтолцоо болон татварын хууль тогтоомж
 - 1.3 Татварын орлогын бүтэц
- Бүлэг 2 Өнөөгийн татварын системд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон түүнийг шийдвэрлэх арга зам
- 2.1 Систем дэх бэрхшээлтэй асуудал
 - 2.2 Систем дэхь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх арга зам
 - 2.3 Өнөөгийн татварын систем дэхь өөрчлөлт шинэчлэлттэй холбогдох санал зөвлөмж
- Бүлэг 3 Татварын Ерөнхий Хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж
- 3.1 «Татвар ногдуулах журам»-ын талаар шинэ заалт оруулах
 - 3.2 ТЭХ-ийн 16,18 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 3.3 «Татварын маргаан таслах зөвлөл»-тэй холбоотой шинэ заалт оруулах
 - 3.4 ТЭХ-ийн 24 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 3.5 «ТМНБ», «ТИНБ»-той холбоотой заалт оруулах
- Бүлэг 4 Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж
- 4.1 Хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.2 Хуулийн 7 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.3 Хуулийн 14 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.4 Хуулийн 16 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.5 Хуулийн 17 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.6 Хуулийн 22 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.7 Хуулийн 23 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах
 - 4.8 Хуулийн 24 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
 - 4.9 Хуулийн 26 дугаар зүйлд өөрчлөлт оруулах

III хэсэг Татвар хураалтын системд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон түүнийг шийдвэрлэх арга зам

- БҮЛЭГ 1** Албан квитанцын систем нэвтрүүлэх нь
- 1.1. Зорилго, ач холбогдол, тайлбар
 - 1.2. Нэвтрүүлэх гэж буй албан квитанцын системийн талаар
 - 1.2.1. Албан квитанцын системийн талаар
 - 1.2.2. Монгол улсад албан квитанцын систем нэвтрүүлэх бололцоо, үндэслэл
 - 1.2.3. Албан квитанцын систем нэвтрүүлэх урьдчилсан нөхцөл
 - 1.2.4. Албан квитанцын системийн хэрэгжилтийн тал дээр нэн даруй авах шаардлагатай арга хэмжээнүүд
 - 1.2.5. Албан квитанцын хуулийн төсөл
- БҮЛЭГ 2** Татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга
- 2.1. «Татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга»-ыг боловсруулсан зорилго
 - 2.2. Татвараа өөрөө тодорхойлох систем болон жишиг татвар
 - 2.2.1. Татвараа өөрөө тодорхойлох системд хамаарах хуулийн заалт
 - 2.2.2. Татварын ногдлыг жишгээр тодорхойлохтой холбогдсон хуулийн заалт
 - 2.3. Татварын ногдлыг жишгээр тодорхойлох тухай журмын заалт
 - 2.4. Татварын ногдлыг жишгээр тодорхойлоход анхаарах зүйл
 - 2.5. Орлогыг жишгээр тодорхойлох арга
 - 2.5.1. Нийт ашиг ба үйл ажиллагааны ашгийг тооцох аргууд
 - 2.5.2. Томъёолол
 - 2.5.3. Татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргын ангилал
 - 2.5.4. Жишгээр тооцох аргын жишээ
- БҮЛЭГ 3** Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар
- 3.1 Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хяналт шалгалтын системд тулгарч буй бэрхшээлтэй асуудал
 - 3.2 Хяналт шалгалтанд тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх арга зам
 - 3.2.1 Хяналт шалгалтын объектыг сонгох аргыг боловсронгуй болгох
 - 3.2.2 Хяналт шалгалтын бэлтгэл шатны ажлыг боловсронгуй болгох
 - 3.2.3 Хяналт шалгалтанд хамрагдах ААНБ-ыг эцэслэн тогтоох
 - 3.2.4 Татвар төлөлтийн хүснэгтийг боловсронгуй болгох
 - 3.2.5 Хяналт шалгалтын аргыг боловсронгуй болгох
 - 3.2.6 Баримт материал бүрдүүлэх системийг төлөвшүүлэх, үр дүнтэй ашиглах
 - 3.2.7 Хяналт шалгалтын байцаагчийн ур чадварыг дээшлүүлэх
 - 3.2.8 Татварын тайлан гаргадаггүй татвар төлөгчийг илрүүлэх

БҮЛЭГ 4 Хөх тайлангийн системийг нэвтрүүлэх нь

- 4.1. Хөх тайлангийн системийн ач холбогдол
- 4.2. Данс бүртгэл хөтлөлтийн өнөөгийн байдал
- 4.3. Хөх тайлангийн систем нэвтрүүлэх талаар
- БҮЛЭГ 5 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах нь
 - 5.1. Асуудал дэвшүүлэх нь
 - 5.2. Асуудлыг шийдвэрлэх арга зам
 - 5.3. Цаашид судалж үзэх чиглэл
- БҮЛЭГ 6 Татварын нягтлан бодох бүртгэлийн систем
 - 6.1. Татварын нягтлан бодох бүртгэл
 - 6.1.1. Өнөөгийн байдал ба бэрхшээлтэй асуудал
 - 6.1.2. Чухал асуудлыг шийдвэрлэх талаарх санал
 - 6.1.3. Анхан шатны нягтлан бодох бүртгэлийн сурах бичгийн ач холбогдол ба зорилго
 - 6.2. Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн систем
 - 6.2.1. Монгол улсад татварын мэргэшсэн нягтлан бодогчийн систем нэвтрүүлж буй өнөөгийн байдал
 - 6.2.2. Япон болон АНУ дахь мэргэшсэн нягтлан бодогч ба татварын мэргэшсэн нягтлан бодогч
 - 6.2.3. Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн систем нэвтрүүлэхийн ач холбогдол
- БҮЛЭГ 7 Хэрэг бүртгэлийн систем
 - 7.1. Хэрэг бүртгэлийн системийн зорилго
 - 7.2. Хэрэг бүртгэх ажлын талаарх ерөнхий ойлголт ба бүтцийн талаарх ерөнхий онол
- БҮЛЭГ 8 Татварын маргаан
 - 8.1. Татварын маргааныг шийдвэрлэж буй өнөөгийн байдал болон тулгарч буй асуудал
 - 8.2. Татварын маргаан шийдвэрлэх аргыг боловсронгуй болгох нь
- БҮЛЭГ 9 Авилгалаас сэргийлэх систем
 - 9.1. Татварын албаны ажилтны авилгалтай холбоотой асуудлууд
 - 9.2. Авилгалаас сэргийлэх ажлыг боловсронгуй болгох нь
- БҮЛЭГ 10 Татвар төлөлтийн орчныг бүрдүүлэх нь
 - 10.1. Татвар төлөгчийн боловсрол
 - 10.2. Татварын зар суртчилгаа
 - 10.3. Бусад арга хэмжээ

ХАВСРАЛТ Судалгааны хэсгээс боловсруулсан татварын хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой санал

Хавсралт 1 Татварын мэдээ баримт цуглуулах, хяналт шалгалтын бэлтгэл шатны ажлын тухай

Хавсралт 2 Монгол улсын татварын ерөнхий хууль (төсөл)

Хавсралт 3 Процессын хууль (төсөл)

Хавсралт 4 Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн хуулийн төсөл, зүйлчилсэн тайлбар

- 4.10 Хуулийн 27 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
- 4.11 Хуулийн 31 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
- 4.12 Хуулийн 35 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах
- 4.13 Хуулийн 36 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
- 4.14 Хуулийн 37 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
- 4.15 Хуулийн 39 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах
- 4.16 Хуулийн 40 дугаар зүйлд өөрчлөлт оруулах
- Бүлэг 5 Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж
 - 5.1 Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тогтмол татвар нэвтрүүлэх тухай
- Бүлэг 6 Хүн амын орлогын албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж
 - 6.1 Хүн амын орлогын албан татварын өнөөгийн байдал
 - 6.2 Хүн амын орлогын албан татварын бүтэц
 - 6.2.1 Татвар ногдох орлого
 - 6.2.2 Татвар ногдох орлого тооцох арга, татвар төлөлтийн арга бүрээр ангилах нь
 - 6.3 Хүн амын орлогын албан татварын хуулийн систем болон хэрэгжилтийн шатан дахь асуудал
 - 6.3.1 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэнд албан татвар ногдуулах
 - 6.3.2 Мал бүхий иргэнд албан татвар ногдуулах
 - 6.4 Дүгнэлт
- Бүлэг 7 Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль болон Хүн амын орлогын албан татварын хуулийн өөрчлөлтөнд хамаарах санал зөвлөмж
 - 7.1 Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогод татвар ногдуулах тухай
- Бүлэг 8 Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн өөрчлөлттэй - холбогдох санал зөвлөмж
 - 8.1 Нэмэгдсэн өртгийн албан татварын өнөөгийн байдал
 - 8.2 Бэрхшээлтэй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам
 - 8.2.1 НӨАТ-ын хэрэгжилтэнд тулгарч буй бэрхшээлтэй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам
 - 8.2.2 Бусад бэрхшээлтэй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам
- Бүлэг 9 Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж
 - 9.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах
 - 9.2 Хуулийн 4 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах
 - 9.3 Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах
 - 9.4 Хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах
 - 9.5 Хуулийн 8 дугаар зүйлийн 2,3 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах
- Бүлэг 10 Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж

Хүснэгт

II ХЭСЭГ

- хүснэгт 1-1 1999 оны төвлөрсөн төсвийн орлогын мэдээ
- хүснэгт 6-1 Хүн амын орлогын албан татварын орлогын биелэлт
- хүснэгт 6-2 Хүн амын орлогын албан татварын үзүүлэлт

III ХЭСЭГ

- хүснэгт 2-1 Гол нэр төрлийн ажил үйлчилгээний үр ашгийн элемент болон үр ашгийн коэффициент
- хүснэгт 2-2 Адил төстэй аж ахуйн үйл ажиллагааны ашгийн түвшин
- хүснэгт 2-3 Хөрөнгө, өр төлбөрийн бууралтаар үйл ажиллагааны ашгийг тооцох нь
- хүснэгт 2-4 Элэгдэл, хорогдлын зардлыг тооцох нь

Хавсралт

- хүснэгт1-1 Татварын холбогдолтой мэдээ баримт цуглуулах маягт
- хүснэгт1-2 Ажил, үйлчилгээний чиглэл бүрээр орлого тооцох жишээ

Товч хураангуй

1. Судалгаа явуулах урьдчилсан нөхцөл

Монгол улсын Засгийн газар Япон улсын Засгийн газарт хандан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад хөгжлийн стратеги, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, эдийн засгийн шинэчлэлийн тодорхой хөтөлбөр боловсруулахад тусламж үзүүлж, Монгол улсын эдийн засгийн бодлого боловсруулах ажилтныг сургаж бэлтгэх зорилгоор хөгжлийн судалгаа хэрэгжүүлэх хүсэлт гаргасан билээ. Энэхүү хөгжлийн судалгаа нь Монгол улсын зах зээлийн эдийн засгийн шилжилтийг дэмжих чиглэлээр 1998 оны 9 сараас 2000 оны 3 сар хүртэл хэрэгжсэн.

Татварын тогтолцоог бэхжүүлэх нь сэдэвт нэгдүгээр шатны судалгаа нь энэхүү хөгжлийн судалгааны нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болж хэрэгжсэн билээ. Уг судалгааны зорилго нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд татварын тогтолцоог бэхжүүлэх санал зөвлөмж боловсруулах, Монгол улсын татварын албаны байцаагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр болох технологи дамжуулахад чиглэж байв. Энэхүү нэгдүгээр шатны судалгааны ажлын үр дүнгийн талаарх эцсийн тайланг 1999 оны 8 сард Монголын талд өргөн барьсан юм. Монгол улсын Засгийн газар татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх судалгааны хэсгийн ажлыг өндрөөр үнэлж энэ салбарт үргэлжлүүлэн хамтран ажиллах талаар Япон улсын Засгийн газарт хүсэлт гаргасан билээ. Япон улсын Засгийн газар бүх төрлийн татвар хураалтыг бэхжүүлж нэгдүгээр шатны судалгаагаар дамжуулсан технологийн үр дүнг улам сайжруулах үүднээс татварын тогтолцоог бэхжүүлэх хоёрдугаар шатны судалгааг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Ингээд 2000 оны 7 сараас 2001 оны 7 сар хүртэл энэхүү хоёрдугаар шатны судалгааны ажил хэрэгжсэн билээ.

2. Судалгааны зорилго

Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдалд (зах зээлийн эдийн засгийн шилжилт) зохицон ажиллаж чадахуйцаар Монгол улсын татвар хураалтын үйл ажиллагааг бэхжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлж алдагдлыг бууруулах зорилгоор татварын хуулийг хэрэгжилтийг сайжруулах, цаашлаад тус улсын төсөв санхүүгийн бааз суурийг бэхжүүлэх нь хоёрдугаар шатны судалгааны ажлын зорилт болон тавигдсан юм. Ялангуяа татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх хоёрдугаар шатны судалгааны ажилд Засгийн газрын хувьд татвар хураалтын механизм болон татвар төлөгчийн хувьд татвар төлөлтийн механизмыг судлах, эдгээр механизмыг гүйцэлдүүлэх татвар төлөлтийн орчинг боловсронгуй болгох, шинэ төрлийн татвар нэвтрүүлэх талаар судлахын зэрэгцээ дээрх асуудлаар санал зөвлөмж бэлтгэж технологи дамжуулахад чиглэж байв. Судалгааны дүнд татварын албаны үйл ажиллагааг илүү үр ашигтай

болгохуйц хуулийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бий болгохыг зорьсон.

3. Нэг ба хоёрдугаар шатны судалгааны үр дүн

Судалгааны нэг, хоёрдугаар шатны ажлын санал зөвлөмжүүдийг Монгол улсын Засгийн газар хүлээн авч өнгөрсөн хугацаанд дараах чиглэлийн ажлуудыг хэрэгжүүлээд байна.

3.1 Нэгдүгээр шатны судалгаа

Монгол улсын Засгийн газар нэгдүгээр шатны судалгааны хэсгийн санал зөвлөмжүүдээс дор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болон хэрэгжүүлж дуусаад байна.

- (a) Бүх шатны татварын албаны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох (2000 оны 2 сар)
- (b) Том татвар төлөгчдөд кассын систем, бусад татвар төлөгчдөд «Үндэсний Татварын Ерөнхий Газрын албан ёсны квитанцийн систем» нэвтрүүлэх шийдвэр (2000 оны 3 сар Санхүү, эдийн засгийн сайд болон Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын тушаал, 2001 оны 1 сарын Засгийн газрын тушаал)
- (c) Татварт хамрагдахгүй байгаа нуугдмал орлогыг илрүүлэх, татвар ногдуулах, хураах дэвшилтэт арга, шинэлэг аргачлал бүхий хяналт шалгалтын гарын авлага, зөвлөмжийг хүлээн авсан. (2000 оны 2 сар)
- (d) Орлогоо нууж татвар төлөхөөс зайлсхийсэн татвар төлөгчдийн талаарх мэдээллийг урамшуулах /үнэлж авах/ тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох
- (e) Татварын байцаагчдын ажлыг үнэлэх, зэрэг дэв дэвшүүлэх, шагнал урамшуулал олгох журмыг шинэчлэх

3.2 Хоёрдугаар шатны судалгаа

Хоёрдугаар шатны судалгааны ажил эхлэх үед Монгол Улсын Засгийн Газраас судалгааны хэсэгт хандаж татварын багц хуулийн өөрчлөлт болон шинэ албан татвар бий болгохтой холбогдсон санал зөвлөмж боловсруулахад хамтран ажиллах талаар хүсэлт гаргасан юм. Судалгааны хэсэг ЖАЙКА-ийн удирдах төвөөс зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр энэхүү хүсэлтийг хүлээн авч 2000 оны 7 сараас 2000 оны 12 сар хүртэлх хугацаанд хуулийн төсөл боловсруулах чиглэлийн ажил хийж холбогдох санал зөвлөмжийг боловсруулж өргөн барьсан билээ.

2001 оны 5 сарын байдлаар Улсын Их Хурлаар татварын хуулийн төсөл хэлэлцэгдэж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар судалгааны хэсгийн санал зөвлөмжийн дагуу дараах гол өөрчлөлт хийгдээд байна.

- (a) Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хууль, онцгой тэмдэгтийн албан татварын хууль шинээр нэвтрүүлсэн.
- (b) Бүх төрлийн татварын хуулийн өөрчлөлт (хүн амын орлогын албан татварын хууль; аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль; нэмэгдсэн өртгийн албан татварын хууль; онцгой албан татварын хууль; автомашин, өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль; авто бензин, дизелийн албан татварын хууль)

Мөн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай татварын албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол хууль болох Татвар ногдуулалт, төлөлтөнд хяналт тавих, татвар хураах тухай хууль болон татварын хуулиудын эх сурвалж болох Татварын Ерөнхий Хуулийн төсөл Улсын Их Хурлаар одоогийн байдлаар хэлэлцэгдэж байна.

3.3 Хоёрдугаар шатны судалгааны ажлын санал зөвлөмжийн ерөнхий агуулга

Энэхүү тайланг боловсруулахдаа нэг, хоёрдугаар шатны судалгааны ажлын явцад олж тогтоосон Монгол улсын төсөв санхүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн төсвийн орлогын эх үүсвэрийг найдвартай, бага зардлаар хангах зорилгоор олон талаас нь нарийн тунгаан үзсэн болно. Иймд зүй зохистой бөгөөд шударга байх, бага зардлаар татвар хураах, хэрэгжүүлэхэд хялбар байх, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байх, татварын суурийг өргөжүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлэх боломжтой бодлого, санал зөвлөмжүүд тайланд голлох байр суурийг эзэлж байна.

Мөн дараах гол чиглэлийг баримтлан энэхүү санал зөвлөмжийг боловсруулав

- a) Монгол улсын өнөөгийн татварын албаны хувьд нэн бэрхшээлтэй асуудал болох далд эдийн засгийн сектор болон бэлэн мөнгөөр арилжаа, үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах, хураах арга барил зэрэг татвараас гадуур орлого олж байгаа татвар төлөгчдөд ямар аргаар нэг мөр татвар ногдуулдаг болох
- b) Татварын хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эцсийн дүндээ татвар төлөгчдөд татвар ногдуулах, татварын хяналт шалгалт хийх, татвар хурааж авахдаа ямар арга зүйгээр ажиллавал илүү үр дүнтэй, нийцтэй байж болох

Дор санал зөвлөмжийн бүлэг тус бүрийн гол агуулгыг дурдав.

(1) Татварын системд тулгарч буй бэрхшээл болон түүнийг шийдвэрлэх арга замын талаар

Энэхүү санал зөвлөмжийн гол агуулгыг дор дурдав.

- (a) Монгол улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх явдлыг нэн тэргүүний зорилго болгохын зэрэгцээ
- (b) Монгол улсын алс хэтийг харсан, татвар төлөгчдийн зүгээс эсэргүүцэл аль болох бага гарах болон тэдний зүгээс нааштайгаар хүлээн авахуйц
- (c) Татварын хуулийн шинэчлэлт болон шинэ татварын төрөл нэвтрүүлэхтэй уялдан гарах татвар хураалтын зардлыг хамгийн доод хэмжээнд байлгах
- (d) Яаралтай буюу зайлшгүй өөрчлөлт хийх, шинээр нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг тусгасан болно.

Нэгэнт баталсан татварын хуулиудад судалгааны хэсгээс онцлон тэмдэглэж байсан санал зөвлөмжөөс бүрэн гүйцэд тусгагдаагүй зүйл ч байгаа тул одоогийн байдлаар Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа Татварын Ерөнхий Хуультай хамт эдгээр шинэчлэх шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн чухал талыг бодолцож үзэн гол татварын төрлүүд дэхь нэмэлт өөрчлөлтийн талаар санал зөвлөмж боловсруулсан. Тайланд татварын гол хууль, процедурын хууль болон одоо үйлчилж байгаа бусад татварын хууль тус бүрээрх шинэчлэх шаардлагатай бодлогын талаар санал зөвлөмж гаргав. Үүнийг дор дурдвал:

- Татварын Ерөнхий хууль
- Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль
- Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль
- Хүн амын орлогын албан татварын хууль
- Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль болон хүн амын орлогын албан татварын хуулинд оруулах нийтлэг өөрчлөлтийн талаар
- Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хууль
- Өв залгамжлал болон бэлэглэлийн албан татварын хууль

(2) Албан ёсны квитанцийн системийг бүрдүүлэх талаар

Тогтоосон үнийн дүн бүхий ажил, үйлчилгээнд хэрэглэх квитанцийг хуульчлах замаар аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн тодорхой үнийн дүнгээс дээшхи ажил үйлчилгээний талаарх нотолгоо баримт болох квитанцийг эцсийн дүндээ улс шууд олж авах боломжтой болох бөгөөд Татварын алба татвар төлөгчийн гаргасан татварын тайлан үнэн зөв эсэхийг шууд тогтоох боломжтой болохын зэрэгцээ татварын тайлан гаргадаггүй татвар төлөгчийг амархан олж илрүүлэх, далд эдийн засгийн сектор болон бэлэн мөнгөөр арилжаа үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах, хураах ажлыг шууд, бага өртгөөр богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой болно. Энэ үүднээс « албан ёсны квитанцийн системийг нэвтрүүлэх» талаар санал зөвлөмж гаргав.

(3) Татварын ногдлыг жишгээр тодорхойлох талаар

Албан ёсны квантанцийн системийг бүрэн гүйцэд хэрэгжүүлсэн тохиолдолд ч гэсэн татвараас зайлсхийхээр завдах татвар төлөгчид мэдээж байсаар байх болно. Үүний зэрэгцээ одоогийн байдлаар татварын тооцоо хийдэггүй, татвараас зайлсхийгчид их байгаа учраас эдгээр татвар төлөгчдийн татвар ногдох орлогыг Татварын алба бодитойгоор жишгээр тогтоож, татвар ногдуулан, хураах асуудал нэн тэргүүний зорилт болон тавигдаж байгаа тул «орлогын жишиг татвар ногдуулах аргын тухай» санал зөвлөмж гаргасан.

Татвараа өөрөө тодорхойлох системд татвар төлөгч өөрөө ажил үйлчилгээтэй холбоотой анхан шатны баримт нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан зэрэг бусад холбогдох бичиг баримтанд тулгуурлан татвар ногдох орлого болон татварын хэмжээг тодорхойлох ёстой. Татварын эрх тэгш байх үндсэн зарчмын үүднээс ажил гүйлгээнийхээ баримтыг бүрдүүлээгүй, бүртгэл хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн гэдэг шалтгаанаар татвараас ангид үлдэж болохгүй нь ойлгомжтой юм. Ийм тохиолдолд данс бүртгэлээс гадна холбогдох бусад нотолгоо болохуйц бичиг баримтанд тулгуурлан татварын ногдлыг жишгээр тогтоох бөгөөд Монгол улсын Татварын Ерөнхий Хууль, Хүн амын орлогын албан татварын хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан журамд тухайн татвар төлөгчтэй ойролцоо хвчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгчтэй харьцуулах замаар татварын ногдлыг жишгээр тодорхойлно гэсэн заалт байдаг. Өнөөгийн байдлаар энэ заалтын дагуу татварын хяналт шалгалтын явцад жишгээр татварын ногдлыг тодорхойлдог.

Гэтэл жишиг татвартай холбоотой маргаан шүүхэд гарахад жишгээр тодорхойлсон татварын ногдлыг үнэн зөв эсэхийг батлах нотлогоо баримт хангалтгүй байдаг тул ихэнх тохиолдолд татварын байцаагчийн шийдвэр хүчингүйд тооцогддогийг анхаарахгүй байж болохгүй. Иймд жишиг татвар ногдуулах тодорхой аргазүйг онолын болон практик талаас нь цэгцэлж татварын байцаагч нарт зааварчилгаа болгох үүднээс гарын авлага боловсруулж технологи дамжуулах семинар зохион байгуулав.

(4) Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын талаар

Монгол улсын ААНБОАТ-ын системд татвар төлөгчийн тайлан үнэн зөв эсэхийг шалгах систем үр ашиг муутай байна гэсэн асуудал гардаг. Тодруулбал, хяналт шалгалтын объектийг сонгох болон хяналт шалгалт хийх аргазүй, хяналт шалгалтын зорилгоор мэдээ баримт цуглуулах системийг дурдаж болно. Эдгээр асуудлыг шийдвэрлэхдээ дараах зүйлд анхаарах хэрэгтэй.

- a) Хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчийг сонгох аргыг боловсронгуй болгох
- b) Хяналт шалгалтын бэлтгэл ажлыг сайжруулах
- c) Татвар төлөлтийн хвснэгтийг боловсруулах
- d) Татварын хяналт шалгалтын аргыг олон төрөлжүүлэх
- e) Туршлага солилцох уулзалт зохион байгуулах

- f) Баримт мэдээлэл цуглуулах оновчтой системийг бий болгох, түүнийг үр дүнтэй ашиглах
- g) Хяналт шалгалтын байцаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

Мөн хүн амын орлогын албан татварын хэсэгт дурдсаны нэгэн адил аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогод 2 хувийн татвар ногдуулж байгаа нь өнөөдөр Монгол улсад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж байгаа, уг үл хөдлөх хөрөнгийг эзэмшигчийн татвар төлөх чадвар зэргийг бодолцож аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын үндсэн хувь хэмжээгээр татвар ногдуулах талаар татварын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй.

(5) Хөх тайлангийн системийг нэвтрүүлэх талаар

Татварын тайлангаа үнэн зөв тодорхойлон цаг хугацаанд нь татвараа төлдөг татвар төлөгчдөд бусад татвар төлөгчтэй харьцуулахад олон талын хөнгөлөлт үзүүлэх замаар татвар төлөх ухамсрыг нь улам дээшлүүлэх, татварын хөнгөлөлт эдлэхийн тулд зохих цаг хугацаанд нь татвараа төлдөг татвар төлөгчдийг нэмэгдүүлэх үүднээс шилдэг татвар төлөгчдийг урамшуулах системийг нэвтрүүлэх талаар санал зөвлөмж гаргасан.

Хөх тайлангийн систем нь өдөр тутмын арилжаа гүйлгээний данс бүртгэлд тулгуурлан орлогын тайлангаа үнэн зөв гаргадаг хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч, аж ахуйн нэгж, байгууллагад данс бүртгэлгүй бусад татвар төлөгчөөс илүү хуульд заасан давуу хөнгөлөлт эдлүүлэх систем юм. Энэ нь татвараа өөрөө тодорхойлдог системийг өргөн хэвшүүлэхэд нэлээн үр дүнтэй арга болохын хувьд ач холбогдол их байдаг.

Гэтэл Монголын татвар төлөгчдийн данс бүртгэл хөтлөж байгаа байдлаас харахад гадаадын хөрөнгө оруулалттай буюу хамтарсан аж ахуйн нэгж, байгууллага болон улсын үйлдвэр зэрэг том аж ахуйн нэгж зарим нэг жижиг дунд үйлдвэрийг эс тооцвол ихэнхи татвар төлөгчид бүх ажил гүйлгээгээ данс бүртгэлд тусгаж, тайлангаа хугацаандаа гаргаж хэвшээгүй байдаг.

Иймд хөх тайлан гаргах татвар төлөгч хөх тайлангийн онцгой хөнгөлөлт зэрэг давуу эрхийг үр ашигтай гэж үзэн эдгээр хөнгөлөлтийг эдлэх сонирхолтой байхуйцаар татварын орчинг боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдах болно. Мөн данс бүртгэл хөтөлдөггүй татвар төлөгчид татварыг жишгээр ногдуулах аргаар татвар ногдуулах ажлыг улам боловсронгуй болгож данс бүртгэлгүй гэсэн шалтаг гарган татвараас зайлсхийх боломжгүй, харин ч данс бүртгэл хөтлөхгүй бол ашиггүй гэж ойлгогдохуйц түвшинд татварын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнтэй уялдаад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн татвар төлөх ухамсрыг дээшлүүлэхийн тулд татварын байгууллагын мэдээлэл сурталчилгаа болон нягтлан бодох бүртгэлийн мэдлэг, данс бүртгэл хөтлөлтийн талаарх сургалтыг эрчимжүүлж тодорхой үр дүнд хүрсэний үндсэн дээр хөх тайлангийн системийг нэвтрүүлэх нь зүйтэй.

(6) Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчдэд ногдуулах албан татварын талаар

Хүн амын орлогын албан татварын хуулинд татварын эрх тэгш зарчим алдагдсан байгааг засч залруулах талаар санал зөвлөмж гаргав.

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчдэд татвар ногдуулах арга нь татварын ачааллыг эрх тэгш хувиарлах зарчимд тохиромжгүй, олон сөрөг үр дагавар бүхий систем тул яаралтай хүчингүй болгож ХАОАТ-ын хуулийн дагуу татвар ногдуулах талаар санал зөвлөмж гаргасан. Гэхдээ уг хуулийг шууд хүчингүй болгох нь татвар төлөгчийн татвар төлөх ухамсар, татварын мэдлэг хомс, данс бүртгэл хөтлөж хэвшээгүй, татварын албаны бүтэц энэ өөрчлөлтөнд бэлэн бус зэрэг олон бэрхшээлтэй асуудал байгаа юм. Хэдийгээр татварын эрх тэгш зарчим алдагдаж байгаа боловч тодорхой хэмжээгээр төсөвт орлого оруулдаг уг татварын хуулийг шууд халахад хүндрэлтэй. Иймд энэ бүлэгт хойшид уг системийг бүхэлд нь халахын өмнөх шилжилтийн шатанд өөрчлөх шаардлагатай дор дурдсан зарим асуудлын талаар санал зөвлөмж гаргав.

- (a) Одоо үйлчилж байгаа хуульд заасан ажил, үйлчилгээний төрлийг багасгаж патентийн хэмжээг бодит байдалд тохируулан өөрчлөх
- (b) Патентийн төлбөрийг жилийн урьдчилсан татвар хэлбэрээр төлүүлж жилийн эцэст тооцоо хийх
- (c) Одоо үйлчилж байгаа хуулийн тайлбар, патентийн төлбөртэй харьцуулахад их хэмжээний ашиг бүхий ажил, үйлчилгээ эрхэлдэг иргэнийг орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэнд оруулж тооцохгүй, ХАОАТ-ын хуулиар татвар ногдуулах

(7) Татварын бүртгэлийн системийн талаар

Зохих түвшинд төсвийн орлогыг хангахын тулд татварын албаны үйл ажиллагааг өөрчлөн шинэчлээд зогсохгүй иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагад татварын нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны талаар өргөн хүрээний мэдлэг олгох, нарийн дадлага сургалт явуулах шаардлагатай тул энэ асуудлаар санал зөвлөмж гаргав. Татварын алба цуглуулах ёстой татвараа бүрэн гүйцэд цуглуулж чаддаггүй нэг шалтгаан нь татвар төлөгчийн нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг хомс байдагтай холбоотой. Монгол улсын Засгийн газар татвар төлөгчдөд давхар бичилтийн системийн дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөхийг зөвлөдөг. Иймд давхар бичилтийн системээр данс бүртгэл хөтлөж хэвшүүлэх, санхүүгийн тайлан боловсруулах, ерөнхий дэвтрээс эхлээд бусад данс бүртгэлийг хөтөлж, хадгалах талаар сайтар зааварчилж шаардах хэрэгтэй. Татвар төлөгчийн нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийг өргөжүүлэхийн тулд загвар болгон судалгааны хэсгээс анхан шатны нягтлан бодох бүртгэлийн сурах бичиг боловсруулаад байна. Татвар төлөгчийн мэдлэг ухамсар дээшилж, данс бүртгэл хөтлөж хэвшвэл орлогыг

нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчдэд ногдуулах албан татварын тухай хууль зэргийг шинэчлэн өөрчилж татвар төлөгдөд тэгш бус ханддаг явдал засрах болно.

Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн систем нэвтрүүлэх нь татварын албаны ажилтаны ухамсрыг дээшлүүлэх нэг арга болох бөгөөд татварын байцаагчийн тэтгэвэрт гарсаны дараах амьдралын болон нийгмийн баталгааг хангахад нөлөөлөх болно. Үүний зэрэгцээ төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Энэхүү системийг нэвтрүүлснээр татвар төлөгчдийн дунд нягтлан бодох бүртгэлийн систем төлөвшөөгүй байгаагын улмаас татварын бүх шатны албадын үйл ажиллагаа, татварын хуулийн хэрэгжилтэнд тулгардаг бэрхшээлийг арилгах боломжтой болно. Татвар, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй татварын мэргэшсэн нягтлан бодогч татвар төлөгчийн хүсэлтийн дагуу түүний татварын тайланг боловсруулах болон бусад татвартай холбоотой бүх үйл ажиллагаанд оролцвол татварыг тооцоо сайн хийгдэж, татвар хугацаандаа төлөгдөж, төсвийн орлого нэмэгдэх нь дамжиггүй юм.

(8) Хэрэг бүртгэлийн системийн талаар

Зөрчил гаргасан татвар төлөгчийг шийтгэж сэрэмжлүүлэх үүднээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх систем болох татварын хэрэг бүртгэлийн системийн талаар Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж бэрхшээлтэй асуудлыг олж тогтоон эдгээр асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал зөвлөмж гаргав.

Хэрэг бүртгэл нь татварын хяналт шалгалтын хамгийн хүчтэй арга бөгөөд хэрэг бүртгэлийг шалгалтанд хамрагдах татвар төлөгчийг ухуулж ойлгуулж чадахуйцаар нарийн бүрэн гүйцэд хийх нь чухал байдаг. Мөн хэрэг бүртгэлийн үр дүнгийн талаар шүүх, хуулийн байгууллагаас итгэл олж авахуйц хариуцлагатай шийдвэр гаргах туршлага, байр суурь бүхий албан тушаалтаны удирдлаган дор хамгийн шилдэг хяналт шалгалтын байцаагч нараас бүрдсэн зохион байгуулалттайгаар хэрэг бүртгэлийн ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

(9) Татварын маргааныг шийдвэрлэх талаар

Монголд татварын байгууллага татвар ногдуулалт, татварын хяналт шалгалт болон татвар хураалтын үйл ажиллагааны талаар татвар төлөгч шүүхэд гомдол мэдүүлсэн тохиолдолд ялагдах явдал олон байдаг. Аливаа татварын маргааныг шийдвэрлэх гол үүд хаалга болох татварын хууль тогтоомжинд заасан эрх үүрэг, хуулийн заалтыг зөрчсөн хэрнээ татвар төлөгч шүүхэд гомдол мэдүүлж татварын алба ялагддаг тохиолдолд байдаг. Эдгээр нөхцөл байдлаас үүдэн татварын маргаан шийдвэрлэх арга замыг боловсронгуй болгох талаар дараах санал зөвлөмжийг гаргав.

- а) Татварын байгууллага, татварын байцаагчийн хууль ёсны эрхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ холбогдох хууль тогтоомжийн бүрхэг зүйл ангийг боловсронгуй болгох хэрэгтэй.

- b) Батламж нотолгоо гаргах чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Татварын байцаагч зайлшгүй бодит баримтан дээр тулгуурлаж түүнийг лавшруулан судлах замаар хяналт шалгалт хийж татвар төлөгч хуурмаг тайлан гаргасан, татвар ногдох орлогоо багасгаж мэдэгдсэн зэрэг зөрчлийг заавал холбогдох нотлох баримтаар батлаж байх ёстой. Аргагүй шалтгаанаар жишиг татвар ногдуулахдаа маргаан үүссэн тохиолдолд ялагдахгүй байхуйц аргыг сонгож татвар ногдуулах хэрэгтэй бөгөөд ийм жишиг татварын аргазүйг ҮТЕГ яаралтай судалж үзэн нэвтрүүлэх хэрэгтэй.
- c) Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй. Татварын маргаан таслах зөвлөл аливаа маргааныг шийдвэрлэхдээ дараагийн шатанд татвар төлөгч шүүхэд гомдол мэдүүлж болзошгүй гэдэг үүднээс нарийн судлах хэрэгтэй. Ийнхүү маргаан таслах зөвлөлийн шийдвэр гарсаны дараа шүүхэд мэдүүлэхээр заасан тохиолдолд уг зөвлөлийн байнгийн гишүүнд Хууль зүй, дотоод хэргийн яам болон шүүх хуулийн байгууллагын ажилтанг оруулах хэрэгтэй.
- d) Татварын алба шүүх хуулийн байгууллагатай хамтарсан (Хууль зүй, дотоод хэргийн яам, Дээд шүүх) байнгийн ажиллагаатай зөвлөл яаралтай байгуулах хэрэгтэй.

(10) Авилгалаас урьдчилан сэргийлэх систем

Авилгал авах хамгийн түгээмэл хэлбэр нь шан харамж авч ногдуулах татварын хэмжээг багасгах явдал юм. Ийнхүү шан харамж авдаг гол шалтгаан нь татварын байцаагчийн ёс суртахууны доголдоос илүүтэйгээр тэдний цалин хөлс бага байдагтай холбоотой. Иймд байцаагчийн ёс суртахууныг дээшлүүлэхийн зэрэгцээ тэдний цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг нэгэн зэрэг авч үзэх хэрэгтэй. Иймд авилгалаас урьдчилан сэргийлэх бодлогын талаар дараах 3 зүйлийн санал зөвлөмж гаргав.

- a) Татварын байцаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх
- b) Авилгалтай холбоотой мэдээлэл шалгах ажилтан томилон ажиллуулах
- c) Татварын байцаагчдийг тогтоосон хугацаанд сэлгэн ажиллуулах системийг боловсронгуй болгох, татварын мэргэшсэн нягтлан бодогчийн системийг нэвтрүүлэх

(11) Татвар төлөлтийн орчинг бүрдүүлэх нь

Татвар төлөгчийн боловсрол болон татварын зар суртчилгааны талаарх нэмэлт санал зөвлөмжүүдийг тусгасан болно.

А Татварын боловсрол

- 1) Татвар төлөх үүргийн ухамсрыг зөвхөн татвар төлөгчдийн хүрээнд бус нийт ард иргэдэд төлөвшүүлэх ёстой. Монгол улсын алс ирээдүйд чиглэсэн татварын сургалтын төлөвлөгөө боловсруулж, бага, дунд сургууль болон их дээд сургуульд татварын боловсрол олгох сургалтыг

тасралтгүй оруулах нь зүйтэй. Татвар төлөгчийн эрх болон үүргийн талаар ирээдүйн татвар төлөгч болох хүүхэд залууст сурах бичгээр дамжуулан төрийн хэмжээнд энэхүү боловсролыг олгох шаардлагатай. Татварын боловсрол гэдгээр зөвхөн төлөх татварын хэмжээг тооцох бүртгэл тооцооны аргыг заах төдий бус энэ нь ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд татвар ямар үүрэг роль гүйцэтгэх зэрэг олон зүйлийг хамрах юм. Иймээс татварын боловсролыг төр нийгмийн тогтолцооны сургалтын нэг хэсэг болгон авч үзэх хэрэгтэй.

- 2) Татварын холбогдолтой төрөл бүрийн судалгааны төвшинг дээшлүүлэх талаарх арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ нь өнөөгийн татварын системийг боловсронгуй болгоход шууд хамааралтай арга хэмжээ болж өгөхөөс гадна дээрх арга хэмжээнд зайлшгүй шаардлагатай, зүйрлэж хэлбэл татварын боловсролын төлөө хийх дэд бүтцийн шинжтэй хөрөнгө оруулалт юм.
- 3) Засгийн газрын аппаратанд татварын судалгааг хөгжүүлэх ажлыг хариуцах хэлтэс (Зөвлөлийн эрх мэдэл бүхий байгууллага байсан нь илүү тохиромжтой. Тодорхой нэг судалгаа хийх тохиолдолд төслийн баг бүхий уян хатан тийм байгууллага ч байж болох юм.) байгуулахыг санал болгож байна.

В Татвар төлөгчдөд зориулсан зар суртчилгаа

- 1) Ердийн хүмүүсийн татварын талаарх мэдлэг сонирхлыг дээшлүүлэх үүднээс ҮТЕГ-аас хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээллийг зохион байгуулалттайгаар өгөх замаар татвар төлөх ухамсрыг дээшлүүлэх тал дээр нухацтай арга хэмжээ авах хэрэгтэй байна. Тухайлбал, тодорхой мөнгөн дүнгээс дээш хэмжээний татвар төлсөн татвар төлөгч болон татвараас зайлсхийгчдийг мэдээлж болох юм.
- 2) Шинээр татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэдэд жилийн (улиралд нэг удаа) хугацаанд татварын төрөл тус бүрээр татварын сургалт явуулж байхыг процессын хуулинд заан өгч, тус сургалтын хамт ҮТЕГ-аас зар сурталчилгааны ажлыг шууд хэрэгжүүлэх хэрэгтэй.
- 3) Татварын талаар зөв зүйтэй ойлголт бүхий татвар төлөгчдийг төлөвшүүлэн зохион байгуулж, татвар төлөх ухамсрыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

Дээр дурдсан санал зөвлөмжийг Монгол Улсын Засгийн Газар түргэн шуурхай хэрэгжүүлсэн тохиолдолд бага өртөг, зардлаар богино хугацаанд татварын орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ татварын эрх тэгш зарчмыг хангаж татварын суурийг нэлээн өргөжүүлэх боломжтой болох тул ойрын хугацаанд хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах хэрэгтэй.

4. Цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаар

Монгол улсын тухайд дараах хэд хэдэн өвөрмөц онцлогтой.

- (a) Хүн амын тоо цөөн, ойролцоогоор 3 сая хүн амтай.
- (b) Иргэд, аж ахуйн нэгж болгон улсаас олгосон тогтоосон дугаартай.
- (c) Татвар төлөгчдийн ухамсар маш сул. Гэхдээ иргэдийн оюуны түвшин харьцангуй өндөр тул зөв арга хэрэглэвэл татварын шинэ арга хэмжээ хэрэгжүүлэхэд хялбар. Үүнийг үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийг шинээр нэвтрүүлсэн байдлаас харахад ойлгомжтой юм.
- (d) Далд эдийн засаг бодитоор оршиж байгаа боловч зохион байгуулалттай хэлбэрт ороогүй.


Дээр дурьдсан өвөрмөц онцлогийг харгалзан Монгол улсын төсвийн орлогыг бэхжүүлэхийн тулд татвар ногдуулалтын адил тэгш байдлыг хангасны үндсэн дээр бүх төрлийн татвар ногдуулалт, хураалтыг шууд хямд зардал, хялбар аргаар богино хугацаанд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх нийт татвар төлөгчдийг хамруулсан албан ёсны квитанцийн системийг бий болгон шуурхай нэвтрүүлэх ёстой.

Дараа нь албан ёсны квитанцийн системийг нэвтрүүлсэн тохиолдолд ч татвараас зайлсхийгч этгээд ямарч нийгэмд байдаг учраас шүүхээр ороход ч ялж гарч чадахуйц жишгээр татвар ногдуулах системийг шуурхай нэвтрүүлэх ёстой.

Эцэст нь хүн амын орлогын албан татвар болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар дахь үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод ногдуулах татварыг тусгай хувь хэмжээгээр тогтоох бус тус тусын хуулинд заасан татварын үндсэн хувь хэмжээгээр ногдуулахаар татварын хуулинд өөрчлөлт оруулах ёстой. Монгол улс, ялангуяа Улаанбаатар хотод үл хөдлөх хөрөнгийн үнэ өсч байна. Үнийн өсөлт дөнгөж эхэлж байгаа энэ үед хөдөлмөрийн бус орлого гэсэн утгаар нь хамгийн багаар гэхэд татварын хуулинд заасан үндсэн хувь хэмжээгээр татвар ногдуулах ёстой. Худалдаж аваад богино хугацаанд борлуулсны орлогод таварын үндсэн хувь хэмжээнээс илүү хэмжээгээр татвар ногдуулах тухай ч судалж үзэх шаардлагатай.

I ХЭСЭГ

УДИРТГАЛ



1. Судалгааны зорилго болон хэрэгжилт

1.1 Судалгааны зорилго

1998 оны 9-р сараас 2000 оны 3 сар хүртэлх хугацаанд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагаас хэрэгжүүлсэн «Монгол улсын зах зээлийн шилжилт болон хөгжлийг дэмжих судалгаа»-ны хүрээнд «Монгол улсын татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх нь» сэдэвт нэгдүгээр шатны судалгааны ажил нь нэн чухал бүрэлдэхүүн хэсэг болж хэрэгжин өндөр үнэлэлт авсан юм. Иймд хоёрдугаар шатанд судалгааны ажлыг үргэлжлүүлсэн бөгөөд энэхүү шатны судалгаа нь 2000 оны 7 сараас 2001 оны 7 сар хүртэл хэрэгжиж байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөлд Татварын албаны бүх төрлийн татвар хураалтын ажлын үр дүнг дээшлүүлэхийн тулд голчлон татварын албаны гүйцэтгэх ажлуудын талаар шинэлэг технологи, арга барил зааж шилжүүлэх, татварын тогтолцоог сайжруулахад чиглэгдсэн юм. Судалгааны эцсийн зорилго нь Монгол улсын төсвийн алдагдлыг бууруулахад хувь нэмэр оруулах, цаашлаад төсвийн суурийг бэхжүүлэхэд оршино.

1.2 Судалгааны үр дүн

Судалгааны нэг, хоёрдугаар шатны ажлын санал зөвлөмжүүдийг Монгол Улсын Засгийн Газар хүлээн авч өнгөрсөн хугацаанд дараах чиглэлийн ажлуудыг хэрэгжүүлээд байна.

(1) Нэгдүгээр шат

Монгол Улсын Засгийн Газар нэгдүгээр шатны судалгааны хэсгийн санал зөвлөмжүүдээс дор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болон хэрэгжүүлж дуусаад байна.

- ① Бүх шатны татварын албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох (2000 оны 2 сар)
- ② Том татвар төлөгчдөд кассын систем, бусад татвар төлөгчдөд «Үндэсний Татварын Ерөнхий Газрын албан ёсны квитанцийн систем» нэвтрүүлэх шийдвэр (2000 оны 3 сар Санхүү, эдийн засгийн сайд болон Хөдөө аж ахуйн сайдын тушаал, 2001 оны 1 сарын Засгийн Газрын тушаал)
- ③ Татварт хамрагдахгүй байгаа нуугдмал орлогыг илрүүлэх, татвар ногдуулах, хураах дэвшилтэт арга, шинэлэг аргачлал, хяналт шалгалтын гарын авлага, зөвлөмжийг хүлээн авсан. (2000 оны 2 сар)
- ④ Орлогоо нууж татвар төлөхөөс зайлсхийсэн татвар төлөгчдийн талаарх мэдээллийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох
- ⑤ Татварын байцаагчдын ажлыг үнэлэх, тушаал дэвшүүлэх, урамшуулах журмыг шинэчлэн боловсруулах

(2) II шат

Судалгааны ажлын II шат эхлэнгүүт Монголын засгийн газраас судалгааны хэсэгт хандаж татварын багц хуулийн өөрчлөлт болон шинэ албан татвар бий болгохтой холбогдсон санал зөвлөмж боловсруулах талаар хүсэлт гаргасан юм. Судалгааны хэсэг ЖАЙКА-ийн удирдах төвөөс зохих зөвшөөрөл авсаны үндсэн дээр энэхүү хүсэлтийг хүлээн авч 2000 оны 7 сараас 2000 оны 12 сар хүртэлх хугацаанд хуулийн төсөл боловсруулах чиглэлийн ажил хийж холбогдох санал зөвлөмж боловсруулж өргөн барьсан.

Судалгааны хэсэг энэхүү санал зөвлөмжийг гаргахдаа

1. Монгол улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх явдлыг нэн тэргүүний зорилго болгохын зэрэгцээ
2. Монгол улсын алс хэтийг харсан, татвар төлөгчдийн зүгээс эсэргүүцэл аль болох бага гарах болон тэдний зүгээс нааштайгаар хүлээн авахуйц
3. Татварын хуулийн шинэчлэлт болон шинэ татварын төрөл нэвтрүүлэхтэй уялдан гарах татвар хураалтын зардлыг хамгийн доод хэмжээнд байлгах
4. Яаралтай буюу зайлшгүй өөрчлөлт хийх, шинээр нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг тусгасан болно.

2001 оны 5 сарын байдлаар Улсын Их Хурлаар татварын хуулийн төсөл хэлэлцэгдэж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар судалгааны хэсгийн санал зөвлөмжийн дагуу дараах гол өөрчлөлт хийгдээд байна.

- ① Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хууль, онцгой тэмдэгтийн албан татварын хууль шинээр баталсан.
- ② Бүх төрлийн татварын хуулийн өөрчлөлт (хүн амын орлогын албан татварын хууль, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, онцгой албан татварын хууль, автомашин, өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль, авто бензин, дизелийн албан татварын хууль)

Мөн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай татварын албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол хууль болох Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль болон татварын хуулиудын эх сурвалж болох Татварын Ерөнхий Хуулийн төсөл Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа бөгөөд ямар өөрчлөлт орж байгаа нь одоогийн байдлаар тодорхойгүй байна.

2. Тус тайлангийн агуулга

Энэхүү эцсийн тайлан нь нэг, хоёрдугаар шатны судалгааны ажлын явцад олж тогтоосон Монгол улсын төсөв санхүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн төсвийн орлогын эх үүсвэрийг найдвартай, бага зардлаар хангах зорилгоор олон талаас нь нарийн тунгаан үзсэний үндсэн дээр зүй зохистой бөгөөд шударга байх, бага зардлаар татвар хураах, хэрэгжүүлэхэд хялбар байх, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байх, татварын суурийг өргөжүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлэх боломжтой бодлого санал зөвлөмжүүд тайланд голлох байр суурийг эзэлж байна.

Түүнчлэн, энэхүү санал зөвлөмж нь нэгдүгээрт, Монгол улсын татварын албаны хувьд нэн бэрхшээлтэй асуудал болох далд эдийн засгийн сектор болон бэлэн мөнгөөр арилжаа, үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах, хураах арга барил зэрэг татвараас гадуурх орлого олж байгаа татвар төлөгчдөд ямар аргаар нэг мөр татвар ногдуулдаг болох, хоёрдугаарт, татварын хуулийн зүй зохистой хэрэгжилтийг хангах зорилгоор эцсийн дүндээ татвар төлөгчдөд татвар ногдуулах, татварын хяналт шалгалт хийх, татвар хурааж авахдаа ямар аргаар ажиллавал илүү үр дүнтэй, зүй зохистой байж болох вэ гэдэг гол чиглэлийг баримтлан санал зөвлөмж боловсруулсан билээ.

Дор санал зөвлөмжийн гол агуулгын талаар дурдав.

- (1) Татварын тогтолцоонд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон шийдвэрлэх арга зам

Судалгааны хэсгээс урьд өмнө онцлон тэмдэглэж байсан хуулийн өөрчлөлттэй холбогдох санал зөвлөмж бүрэн гүйцэд тусгагдаагүй байгаа бөгөөд өнөөгийн байдлаар Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа Татварын Ерөнхий Хууль болон бусад татварын хуулиудын өөрчлөх шаардлагатай чухал зүйл ангиудын талаар санал зөвлөмж гаргасан билээ.

Хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон түүнийг шийдвэрлэх арга зам

Эдгээр гурван гол татварыг төсвийн орлогыг бүрдүүлэхэд гол тулгуур болгон татварын удирдлагыг зүй зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хуулийн хэрэгжилтэнд тулгарч буй асуудлыг олж тогтоохын зэрэгцээ түүнийг өөрчлөн шинэчлэх бодлогын талаар дараах санал зөвлөмжийг гаргасан.

- (2) Албан ёсны квитанцийн систем нэвтрүүлэх талаар

Тодорхой тогтоосон үнийн дүн бүхий ажил, үйлчилгээнд хэрэглэх квитанцийг хуульчлах замаар аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн тодорхой үнийн дүнгээс дээш ажил үйлчилгээг эцсийн дүндээ улс шууд олж мэдэх боломжтой болох бөгөөд Татварын алба татвар төлөгчийн

гаргасан татварын тайлан үнэн зөв эсэхийг шууд тогтоох боломжтой болохын зэрэгцээ татварын тайлан гаргадаггүй татвар төлөгчийг амархан олж илрүүлэх, далд эдийн засгийн сектор болон бэлэн мөнгөөр арилжаа үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах, хураах ажлыг шууд, бага өртгөөр богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой болно. Үүний тулд « албан ёсны квитанцийн системийг нэвтрүүлэх» талаар санал зөвлөмж гаргасан.

(3) Орлогын жишиг татвар

Албан ёсны квитанцийн системийг бүрэн гүйцэд хэрэгжүүлсэн тохиолдолд ч гэсэн татвараас зайлсхийхийг оролдох татвар төлөгчид мэдээж байсаар байх болно. Үүний зэрэгцээ одоогийн байдлаар татвараас зайлсхийгчдийн тоо их байгаа тул эдгээр татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжинд заасан татвар ногдох орлогыг Татварын алба бодитойгоор жишгээр тогтоож татвар ногдуулан, хураах асуудал нэн тэргүүний зорилт болон тавигдаж байгаа тул «орлогын жишиг татвар ногдуулах аргын тухай» санал зөвлөмж гаргасан.

(4) Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар

Монгол улсын аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тогтолцоон дахь татвар төлөгчийн тайлангийн зөв эсэхийг шалгах хяналт шалгалтын систем нь үр дүн муутай байна. Тодруулбал хяналт шалгалтын объектыг сонгох, хяналт шалгалтын бэлтгэл ажлын арга зүй, хяналт шалгалтын арга зүй, татварын баримт материал бүрдүүлэх зэрэг учир дутагдалтай асуудлууд байгаа бөгөөд уг тайланд эдгээр асуудлыг шийдэх арга замын талаар зөвлөмж боловсруулж тусгасан.

(5) Хөх тайлангийн системийн тухай

Татварын тайлангаа үнэн зөв тодорхойлон цаг хугацаанд нь татвараа төлдөг татвар төлөгчдөд бусад татвар төлөгчтэй харьцуулахад олон талын хөнгөлөлт үзүүлэх замаар татвар төлөх ухамсрыг улам дээшлүүлэх, татварын хөнгөлөлт эдлэхийн тулд зохих цаг хугацаанд нь үнэнч шударгаар татвараа төлдөг татвар төлөгчид нэмэгдэнэ гэсэн үүднээс шилдэг татвар төлөгчдийг урамшуулах системийг нэвтрүүлэх талаар санал зөвлөмж гаргасан.

(6) Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч иргэнд татвар ногдуулахад тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон түүнийг шийдвэрлэх арга зам

Хүн амын орлогын албан татварын хуулинд татварын эрх тэгш зарчим алдагдсан байгааг засч залруулах санал зөвлөмж гаргасан.

(7) Татварын нягтлан бодох бүртгэлийн системд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон түүнийг шийдвэрлэх арга зам

Зохих түвшинд төсвийн орлогыг хангахын тулд татварын албаны үйл ажиллагааг өөрчлөн шинэчлээд зогсохгүй иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагад татварын нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны талаар өргөн хүрээний мэдлэг олгох, нарийн дадлага сургалт явуулах шаардлагатай тул энэ асуудлаар санал зөвлөмж гаргасан.

(8) Татварын хэрэг бүртгэлийн системийн тухай

Зөрчил гаргасан татвар төлөгчийг шийтгэж сэрэмжлүүлэх үүднээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх систем болох татварын хэрэг бүртгэлийн системийн талаар Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж бэрхшээлтэй асуудлыг олж тогтоон эдгээр асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал зөвлөмж гаргасан.

(9) Татварын маргааныг шийдвэрлэх хууль зүйн орчинг боловсронгуй болгох

Татварын маргаан гарахад яагаад Татварын алба ихэвчлэн ялагддаг талаар судалж үзэн санал зөвлөмж гаргасан.

(10) Татварын албан хаагчид хээл хахуул авахаас урьдчилан сэргийлэх системийн талаар

Газар авсаар байгаа татварын албан хаагчдын албан тушаалаа урвуулан ашиглах явдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар судалж үзсэний үндсэн дээр санал зөвлөмж боловсруулсан.

(11) Татвар төлөгчийн боловсрол, татварын мэдээлэлийн системийг боловсронгуй болгох талаар

Татвар төлөгчийн боловсрол, татварын зар сурталчилгааны бодлогын талаар нэмэлт санал зөвлөмж гаргасан.

Дээр дурдсан санал зөвлөмжийг Монгол Улсын Засгийн Газар түргэн шуурхай хэрэгжүүлсэн тохиолдолд бага өртөг, зардлаар богино хугацаанд татварын орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ татварын эрх тэгш зарчмыг хангаж татварын суурийг мэдэгдэхүйц өргөжүүлэх боломжтой болох тул ойрын хугацаанд хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах хэрэгтэй.

3. Судалгааны хэсгийн удирдлага, зохион байгуулалт

Хоёрдугаар шатны судалгаа 2000 оны 7 сараас 2001 оны 7 сар хүртэл хэрэгжсэн. Судалгааны ажлын бүрэлдэхүүнийг дор дурдав.

(1) Хяналтын завлөлийн гишүүд

Овог нэр	Хариуцсан ажил	Албан тушаал
Асанума Шинжи	Зөвлөлийн дарга	Хитоцубаши их сургуулийн олон улсын үйлдвэрлэлийн стратеги бодлого судалгааны тэнхим профессор
Үэно Хироши	Гишүүн	Кобэ их сургуулийн олон улсын хамтын ажиллагаа судалгааны тэнхим профессор
Кимото Сатоко	Гишүүн	Татварын Ерөнхий Газрийн харъяа татварын коллежийн судалгааны факультет профессор

(2) Судалгааны хэсгийн гишүүд

Овог нэр	Хариуцсан ажил	Албан тушаал
Кояанаги Юүжиро	Нэгтгэн удирдах (татварын бодлого) татвар төлөлтийн орчин	Санхүүгийн судалгааны хүрээлэн
Хирано Ёшиаки	Татварын бүтэц / ААНБОАТ	Нихон их сургуулийн бизнесийн ухааны факультет профессор
Хоригүчи Казуяя	Татварын бүтэц / НӨАТ	Канто их сургуулийн эдийн засгийн факультет профессор
Ватабэ Ёшинобу	Татварын бүтэц / ХААОТ	Санхүүгийн судалгааны хүрээлэн
Вада Сэймэй	Татварын нягтлан бодох бүртгэл	Санхүүгийн судалгааны хүрээлэн
Канэмура Такафуми	Татварын хууль, татварын систем	Мэйкай их сургуулийн эдийн засгийн факультет профессор

(3) Хамтран ажилласан талын гол гишүүд

Овог нэр	Албан тушаал
Я. Батцоож	ҮТЕГ-ын хэлтсийн дарга
Б. Эрдэнэбаатар	ҮТЕГ-ын хэлтсийн дарга
Б. Норжинлхам	ҮТЕГ-ын хэлтсийн дарга
Л. Бадамцэцэг	ҮТЕГ-ын хэлтсийн дарга
Ж. Бавуусүрэн	ҮТЕГ-ын Улсын бүртгэлийн албаны дарга
Я. Пүрэвэ	ҮТЕГ-ын Сургалт, мэдээллийн төвийн захирал
Д. Баяраа	ҮТЕГ-ын Сургалт, мэдээллийн төвийн багш
О. Цогт	ҮТЕГ-ын татварын улсын ахлах байцаагч
С. Төгөлдөр	ҮТЕГ-ын татварын улсын байцаагч
С. Мятавжанцан	ҮТЕГ-ын татварын улсын ахлах байцаагч
Ч. Золбаяр	ҮТЕГ-ын татварын улсын байцаагч
Ш. Ганчимэг	ҮТЕГ-ын Сургалт, мэдээллийн төвийн багш
Я. Аюушжав	НТГ-ын хэлтсийн дарга
М. Гомбосүрэн	НТГ-ын татварын улсын байцаагч
А. Сарантуяа	НТГ-ын татварын улсын байцаагч

4. Өргөн барих тайлан

Судалгааны тайлан нь дор дурдсан агуулгатай байна.

- Товч хураангуй
- Эцсийн тайлан
- Нягтлан бодох бүртгэлийн сурах бичгийн загвар
- Татварын байцаагчдын гарын авлага

Эцсийн тайланд өнөөг хүртэл хийгдсэн судалгааны үр дүнг нэгтгэн тусгасан байна. Мөн нягтлан бодох бүртгэлийн сурах бичгийн загвар нь татварын бүртгэлд шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн үндсийн талаар бичсэн байх бөгөөд сургалтын материал болгон цаашид ашиглаж болохуйц загвар боловсруулсан. Түүнчлэн татварын байцаагчдын гарын авлага нь жишиг татвар ногдуулах аргачлал болон татварын хяналт шалгалтын арга гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд эдгээрийг татварын байцаагчдад технологи шилжүүлэн эзэмшүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газарт өргөн барих юм.

II ХЭСЭГ

ТАТВАРЫН СИСТЕМ

Бүлэг 1

1. Санхүү ба татварын системийн өнөөгийн байдал

1.1 Санхүүгийн өнөөгийн байдал ба татварын бодлого

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш анх удаа 1993 онд татварын шинэчлэлт хийгджээ. Тухайн үед гадаадын тусламжийн байгууллагуудын заавар зөвлөмжөөр татварын ерөнхий хууль, хүн амын орлогын албан татварын хууль, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хууль, борлуулалтын татвар, хэрэглээний татвар гэх мэт хууль батлагдан гарч, орлогын албан татвар төвтэй татварын систем бүрэлдэн тогтжээ. Түүнээс хойш 1997 онд татварын ерөнхий хууль гэх мэт хуулинд нэмэлт өөрчлөлт орж, 1998 онд НӨТ-ын хууль батлагдаж, борлуулалтын татварын оронд Европын холбооны улсын хэв загварын НӨТ нэвтэрсэн байна. Энэ үеэс Монгол улсын одоогийн татварын системд орлогын татвараас хэрэглээний татвар гол байр суурь эзлэх болсон байна.

Монгол улс нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш 10 жилийн нүүр үзэж байна. Энэхүү хугацаанд Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж ирсэн татварын бодлогод төсвийн байнгын алдагдлыг багасгах үүднээс гадаадын тусламжийн байгууллагуудын заавар зөвлөмжийн дагуу татварын орлогын өсөлтийг хангах явдалд гол анхаарал хандуулж ирсэн байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн зогсонги байдал, татвар төлөгчдийн ухамсар доогуур байдал зэргээс татварын орлого ойрын хэдэн жилд ч хангалттай орж ирэхгүй байгаа бөгөөд 1999 оны санхүүгийн алдагдал 85000 сая орчим төгрөг, ДНБ-тэй харьцуулахад энэ нь - 8,5% болж байгаа бөгөөд урьдын адил их хэмжээний алдагдал гарсаар байна.

Иймээс 2000 оны 7 сард гарч ирсэн МАХН-ын удирдах шинэ засгийн газар сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хүн амын болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварыг багасгах зорилт дэвшүүлж байсан ч 2001 оны татварын системийн шинэчлэлээр татварыг бууруулах бус санхүүгийн алдагдлыг багасгах үүднээс татварын орлогыг өсгөх бодлогыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлжээ. Хүн амын болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хувь хэмжээг урьдын хэвээр нь үлдээж, НӨТ-ыг 13% байсныг 15% болгохоор шийдвэрлэжээ. Мөн Монгол улсын засгийн газар татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор тус судалгааны хэсгийн зүгээс гаргаж буй санал зөвлөмжийг судлан үзэж, татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх ажил дээр анхаарч ажиллаж байгаа билээ.

1.2 Өнөөгийн татварын тогтолцоо ба татварын хууль тогтоомж

Монгол улсын одоогийн татварын тогтолцоонд татварын нийтлэг хууль болох татварын ерөнхий хууль, улсын татварын хууль болох хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар, гаалийн албан татвар, НӨТ, онцгой албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, өв залгамжлал бэлэглэлийн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нийслэл хотын албан татвар, хот суурин газрын нохойны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, автобензин дизелийн түлшний албан татвар, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын төлбөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, ус ашигласны төлбөрийн 19 төрлийн татварын хууль, орон нутгийн татвар болох ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, байгалийн ургамал ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, рашаан ашигласны төлбөр гэх мэт 5 төрлийн татварын хууль, татварын хэрэгжилтийг зохицуулах хууль болох процессын хууль тус тус үйлчилж байна. Энэ дотроос улсын татварын гол хууль болох өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын хууль нь бодит амьдрал төдийлөн хэрэгжихгүй, татварын тогтолцооны хүрээнд л оршиж байна.

Татварын хувь хэмжээний хувьд улсын татварыг УИХ, орон нутгийн татварыг ИТХ тогтоох тухай заасан байдаг. Одоогийн хүн амын орлогын албан татварын хувь хэмжээ нь 15, 40 гэсэн 2 шатлалтай, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар нь 40%, НӨТ 15%-тай байгаа билээ. Одоогийн нөхцөлд бодит амьдралд хэрэгжиж байгаа бөгөөд татварын гол хуулиуд нь хүн амын орлогын албан татварын хууль, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, гаалийн албан татварын хууль, НӨТ-ын хууль, онцгой албан татварын хууль, онцгой тэмдгийн хууль, үл хөдлөх хөрөнгийн албан татварын хууль, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль, бензин, дизелийн түлшний албан татварын хууль, татварын ерөнхий хууль, процессын хууль болно.

Татварын ерөнхий хуульд улсын болон орон нутгийн албан татварын ангиллыг зааж өгсөн хэдий ч бодит байдал дээр улсын албан татварыг ч орон нутагт хуваарилах тохиолдол байдаг.

1.3. Татварын орлогын бүтэц

1999 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын үзүүлэлтийг 1-р хүснэгтэд харуулсан болно. Нийт орлогын хэмжээ 2,59400 сая төгрөг, зарлага нь 3,44300 сая төгрөг, төсвийн алдагдал 84000 сая төгрөгтэй гарчээ. Төсвийн орлогыг бүтцээр нь авч үзвэл татварын орлого болон татварын бус орлого 92,8%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний дараа төрийн өмч худалдсанаас орж ирсэн орлого гэх мэт хөрөнгийн шинжтэй орлого 4,6%, гадаадын тусламжийн хөрөнгө 2,6%-ийг эзэлж байна.

Хүснэгт 1-1 1999 оны улсын төвлөрсөн төсвийн үзүүлэлт

(Нэгж: сая төгрөг)

Нийт орлого ба татаас	259,437,0	(100,0%)		
Урсгал орлого		240,795,8	(92,8%)	
Татварын орлого			182,510,7	(70,3%)
1 Орлогын албан татвар				41,932,7
2 НДШ				29,707,2
3 НӨТ				58,863,6
4 Онцгой татвар				26,667,7
5 Хөрөнгийн татвар				820,9
6 Гадаад худалдааны татвар				9,011,0
7 Бусад				16,007,6
Татварын бус орлого			58,285,1	(22,5%)
Хөрөнгийн орлого		11,948,6	(4,6%)	
Гадаад татаас		6,692,7	(2,6%)	

Татварын орлого нь нийт төсвийн орлогын 70,3%-ийг эзэлж байна. Татварын орлого хамгийн ихтэй татварын төрөл нь НӨТ бөгөөд нийт татварын орлогын 32%-ийг эзэлж байна. Үүний дараа хүн амын орлогын албан татвар болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар 23%, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 16%-ийг эзэлж байна. Ийнхүү НӨТ хамгийн их орлоготой гол татварын нэг болоод байна. НӨТ дээр хэрэглээний татварыг нэмбэл нийт татварын орлогын 60% орчмыг эзлэх юм. Шууд болон шууд бус татварыг орлогоор нь харьцуулбал 4:6-гийн харьцаагаар шууд бус татвар их байгаа ба эндээс шууд бус татвар төвтэй татварын систем Монгол улсад оршин байна гэж үзэж болно.

Бүлэг 2

2. Өнөөгийн татварын системд тулгарч буй асуудал ба түүнийг шийдвэрлэх арга зам

2.1 Системд тулгарч буй бэрхшээлтэй асуудал

Татварын систем нь ард иргэдийн дэмжлэгийг хүлээж байхын тулд нэгдүгээрт системийнхээ хүрээнд тэгш шударга байх ёстой байдаг. Энэ нь татварын систем тэгш шударга бус байвал ард иргэд татварын системийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд эндээс татвар хураалтад бэрхшээл учирна гэсэн үг юм. Татварын систем тэгш шударга байна гэдэг нь татварын ачаалал ард иргэдэд тэгш шударгаар хуваарилагдан очих ёстой гэсэн санааг агуулна. Хоёрдугаарт, татварын систем нь үндэсний эдийн засагт үр ашиг авчирч байх ёстой. Үр ашигтай байх зарчим нь татвар ногдуулалтаар эдийн засгийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар бий болгохгүй байх шаардлагыг татварын системд тавьдаг. Дээр дурдсан хоёр зарчим нь нэг нь нөгөөдөө харшилж байдаг тул аль алиныг нь мөрдөх нь хэцүү хэдий ч цаг үеийнхээ эдийн засаг нийгмийн байдалд тохируулан ард иргэдийн зүгээс хүлээн зөвшөөрөх татварын системийг бий болгохын тулд яах аргагүй эдгээр зарчмыг харгалзаж үзэх шаардлагатай юм.

Дээрх тэгш шударга байдлын болон үр ашгийн зарчмыг хэмжүүр болгон одоогийн татварын системийг авч үзэхэд доорхи 3 бэрхшээлтэй асуудал байна.

Нэгдүгээрт, Монгол улсад татварын системийг анх бүрдүүлэхдээ эдийн засаг нийгмийн байдлыг нэг их харгалзан үзээгүйгээс энэхүү систем нь ихээхэн тэгш шударга бус, үр ашиггүй систем болсон явдал юм. Үүнийг татварын бүхэл бүтэн тогтолцоо, тухайн татварын системийн аль алин дээр хэлж болно. Одоогийн татварын тогтолцоонд хүн амын болон аж ахуйн нэгж байгууллагын албан татвар, НӨТ-ын хэрэглээний татвар гол байр эзэлж буй боловч Монголын өнөөгийн нөхцөл байдлаас харахад үндэсний орлого олоход бэрхшээл байсаар байгаа бөгөөд ерөнхийдөө том аж ахуйн нэгжүүд болон цалингийн орлоготой иргэд л татварт хамрагдаж, тэгш шударга байдал энд алдагдаж байна. Мөн НӨТ дээр ч зарим аж ахуйн нэгжүүд л татварт хамрагдаж, шударга байдлын зарчим алдагдаж байна.

Хоёрдугаарт, орлого болон хэрэглээний татварыг зөвхөн том аж ахуйн нэгжүүдээс л авч буй нь аж ахуйн үйл ажиллагаа явуулах идэвх санаачилгыг хаан боогдуулж үр ашиггүй байдал үүсгэж байна. Энэ нь жижиг аж ахуйн нэгжүүдийн тоог өсгөж, аж ахуйн үйл ажиллагааг үр ашиггүй зогсонги байдалд хүргэж мэдэх юм.

Гуравдахь асуудалтай тал бол татварын систем нь улс болон орон нутгийн хэрэгцээг бүрэн дүүрэн санхүүжүүлж чадахгүй байгаа явдал юм. Төсөв санхүү байнгын алдагдалтай, төсвийн орлого зарлагаасаа бага гарч, татварын орлого дутсаар байна. Мөн татварын ерөнхий хуулинд хэдийгээр улсын болон орон нутгийн татвар гэж зааглан тогтоож өгсөн боловч бодит амьдрал дээр орон нутагт хураасан орлогын албан татвар улсад очилгүй

тухайн орон нутагт очих тохиолдол гардаг аж. Орон нутгийн төсөв ч мөн адил байнгын алдагдалтай байгаа бөгөөд улс, орон нутгийн төсөв санхүүг эрүүлжүүлэх шаардлага тавигдаж байна.

Эцэст нь системийн хүрээнд тулгарч буй чухал асуудалд процессын хууль болон татварын ерөнхий хуулийн талаар авч үзэхгүй бол болохгүй. Энэ нь төсвийн орлогыг зохих төвшинд бүрдүүлэхэд татварын хуулиуд нь бүх татвар төлөгчдөд үйлчлэх ёстой нь мэдээжийн хэрэг боловч Монгол улсын одоогийн татварын ерөнхий хууль болон процессын хууль нь татварын зохих хэрэгжилтийг өөрөө хаасан тийм заалт агуулсан тохиолдол нэлээд олон байгаатай холбоотой. Хэчнээн сайн татварын хууль батлаад тэр нь хэрэгжилтийн тал дээр туйлын тааруу бол төсвийн орлогын өсөлтийг хангах талаар ярих ч хэрэггүй юм. Иймээс татварын зохих хэрэгжилтэнд саад болж буй зүйл заалтуудыг үтэр түргэн эргэн харах шаардлагатай байна.

2.2 Тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх нь

Өнөөг хүртэлх хугацаанд Монгол улсын татварын систем нь гол гол татварын орлогыг нэмэгдүүлэх явдлыг нэн тэргүүний зорилго болгож, тухай бүрд өөрчлөлт хийсээр иржээ. Гэхдээ эдгээр өөрчлөлт нь бүгдээрээ биш ч гэсэн гадаадын тусламжийн байгууллагын хүсэлт шаардлагын дагуу хийгдсэн зүйлс бөгөөд үүний улмаас зарим тохиолдолд татварын эрх тэгш байдлын болон дундыг баримтлах зарчим алдагдах явдал гарч байжээ. Иймэрхүү хүсэлт шаардлагыг санхүү эдийн засгийн байдал хөл дээрээ тогтох хүртэл хүлээж авахаас өөрцгүй бөгөөд богино хугацаанд түүнийг урьдчилсан нөхцөл болгон авч үзэх шаардлагатай юм.

Одоогийн татварын системийг нэвтрүүлэхдээ тэргүүний хөгжилтэй орнуудын татварын системийг бараг тэр хэвээр нь хуулбарласан тул хөгжих шатандаа явж буй Монгол улсад энэ нь тэр бүр тохирохгүй системийн болон татвар хураалтын тал дээр дээр дурдсан шиг бэрхшээлтэй асуудлууд гарсаар байна. Системийн хүрээнд тулгарч буй асуудалд дээр 4 зүйл дурдсан бөгөөд эдгээр асуудлуудыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

Юуны өмнө татварын системийн тэгш шударга байх тал дээр бүхэл бүтэн системийн хүрээнд онолын үүднээс оновчтой шийдвэрлэх шаардлагатай. Татварын орлогын өсөлтийг хангах ёстой гээд эдгээр зарчмыг богино хугацаанд зөрчиж болох хэдий ч урт хугацаанд онолын шаардлагын дагуу татварын системийг бүрдүүлэх нь чухал. Мөн татварын системийн асуудал нь хувийн салбарынхантай ч ихээхэн холбоотой тул үр ашигтай байх зарчмын үүднээс татварын систем нь тодорхой бизнесийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх ёстой юм. Иймээс улс, орон нутагт татварын орлогыг хуваарилах асуудлыг системтэйгээр зохион байгуулах хэрэгтэй ба санхүү зохицуулалтын системийг нэн даруй хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Татварын орлогын бүрдэлтийг хангах ажлыг үр ашигтай бөгөөд зүй зохистой хэрэгжүүлэхэд ялангуяа татварын хэрэгжилтийг үр ашигтай, зүй зохистой явуулах орчин зайлшгүй шаардлагатай болно. Энэхүү процессын хууль болон татварын ерөнхий хуулин дахь татварын хэрэгжилтийн асуудлыг процессын хуулин дахь үр ашигтай болон зүй зохистой байдлыг шалгуур болгон шийдвэрлэх хэрэгтэй.

2.3 Өнөөгийн татварын системийг боловсронгуй болгох талаарх санал

Монгол улсын татварын систем нь зах зээлийн эдийн засгийн хөгжилтэй уялдан аажим боловч хөгжсөөр байна. Цаашдын татварын системийн хөгжлийг авч үзэхдээ татварын систем нь санхүүгийн системд чухал байр эзлэх тул харилцаа холбоо бүхий системтэй зохицолдох зохицолдоог сайтар харгалзан үзэж шийдвэрлэх хэрэгтэй. Төсвийн системтэй харьцах харьцааны хувьд татварын систем нь одоогийн татварын хувь хэмжээгээр татварын орлогыг хэр зэрэг бүрдүүлэх бололцоотой вэ гэдгийг оновчтойгоор гаргаж үзүүлэх шаардлагатай, мөн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхдээ гол бодлогын хүрээнд татварын системийг авч хэрэглэх явдал мөн шаардлагатай. Цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал зүйл бол урт хугацааны тогтвортой системийг төлөвшүүлэхийг зорьж буй бол Монгол улс өөрөө бие дааж системийн шинэчлэлт хийж, тэгш шударга байдлыг эн тэргүүнд авч үзэх явдал болов уу.

Дараагийн бүлэгт бид өнөөгийн татварын системд чухал байр эзэлдэг татварын ерөнхий хууль, процессын хууль болон гол гол татварын хуулиуд дээр тулгуурлан түүнийг өөрчилж боловсронгуй болгох талаарх саналыг дэвшүүлэх болно.

Бүлэг 3

3. Татварын ерөнхий хуулинд өөрчлөлт оруулах тухай санал

Татварын ерөнхий хуулинд өөрчлөлт оруулах талаарх санал нь дараах маягтай юм.

3.1 «Татвар ногдуулах журам»-ын талаар шинэ заалт оруулах талаар

ТЕХ-д «Татвар ногдуулах журам» гэдэг зүйл оруулж, дараах зүйлүүдийг тусгах хэрэгтэй.

(1) «Бодит татвар ногдуулалт, хураалтын зарчим»

Татварын алба нь татвар төлөгчид татвар ногдуулах, хураах ажиллагааг тухайн орлого, хөрөнгийн эзэмшлээс (тухайлбал, хэний нэр дээр, ямар нөхцөл байдалд байгааг) үл хамааран бодит байдалд тулгуурлан явуулна.

Тайлбар

Энэхүү заалт нь татварын алба татвар төлөгчид татвар ногдуулалт, хураалтын үйл ажиллагааг явуулахдаа татвар ногдох орлого, эд хөрөнгө нь зөвхөн тухайн татвар төлөгчийн нэр дээр байгааг харгалзах биш харин түүнийг бодит байдал дээр тулгуурлан явуулах боломжийг олгосон заалт болно.

Энэхүү заалтыг оруулснаар бусдын нэр дээр орлого, эд хөрөнгөө бүртгүүлж, татвараас зайлсхийх, эсхүл татвар хураалтаас зугтаж буй татвар төлөгчид татвар ногдуулахдаа бодит байдлыг харгалзан явуулах бололцоог бий болгож байгаа тул татварын албаны үйл ажиллагаа илүү үр дүнтэй явагдах болно гэж үзэж байна.

Жишээ 1

А татвар төлөгчийн нэр дээр хийгдсэн борлуулалт В татварын албан дээр бүртгэлтэй тохиолдлыг авч үзье. Энэ тохиолдолд татварын хяналт шалгалтаар С татварын албан дээр бүртгэлтэй D татвар төлөгчийн борлуулалт үнэн хэрэг дээрээ А татвар төлөгчийнх болох нь илэрсэн (D татвар төлөгчийн нэр дээрх борлуулалтаас олсон ашиг татвар төлөгч А-д шилжсэн байв.) тул татвар төлөгч А-д татвар төлөгч D-гийн борлуулалтын орлогыг нэмж тооцож татварын ногдолт хийх тохиолдолд

Жишээ 2

Татвар төлөгч E татвар төлөхгүй байгаа тул түүний компаний сейфийг шалгахад түүний эхнэр болон ажилтнуудынх нь нэр дээр их хэмжээний хадгалуулсан мөнгө байгааг илрүүлсэн байна. Эдгээр мөнгөний шилжилт хөдөлгөөнийг шалгахад тэр нь татвар төлөгч E-гийн мөнгөний

тодорхой бус зарцуулалт хийсэн өдөртэй тохирч байсан тул энэхүү мөнгийг татвар төлөгч Е-гийнх гэж үзэн хураан авсан байна.

(2) «Хөх тайлангийн систем»

Татвар төлөгч нь гаргасан тайлангийнхаа дагуу татвар төлдөг тул өөрийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой анхан шатны баримт, шаардлагатай гэж үзсэн бусад баримт бүртгэл, татварын хуулинд заасан татварын тайлан гаргахад шаардлагатай төрөл бүрийн баримтыг бүрдүүлж, бодит арилжаа бизнесийн үйл ажиллагаагаа үнэн зөв бичиж тэмдэглэсний үндсэн дээр тайлангаа гаргаж, татвараа төлж буйг татварын алба нь хүлээн зөвшөөрч буй тохиолдолд татвар төлөгчийн татвар төлөх үүргийг тодорхойлсон татварын хууль болон сангийн сайдын тушаалын дагуу хөх тайлангийн урамшуулалт системээр тухайн татвар төлөгчид тусгай хасалт зэргийг хийж өгч болно.

Тайлбар

Энэхүү хөх тайлангийн систем нь татварын хууль болон татварын албанаас тавигдах шаардлагын дагуу өөрийн үйл ажиллагааг үнэн зөв байдлаар бүртгэл тооцоондоо тусгахын зэрэгцээ түүнийхээ үндсэн дээр татварын тайлангаа үнэн зөв гаргаж, татвараа төлж буй татвар төлөгчид бусад татвар төлөгчдөөс татварын илүү давуутай нөхцөл байдал олгож урамшуулах хэрэгтэй бөгөөд энэ нь мөн Монгол улсын татварын тайлан гаргах гэх мэт татвар төлөлтийн системийн хөгжилд нааштай байдлаар нөлөөлөх тул татварын алба нь энэхүү системийг нэвтрүүлэх нь зүйтэй гэж хүлээн зөвшөөрвөл татвар төлөгчид татварын тайлан гаргах заалт бүхий татварын хууль болон Санхүү, эдийн засгийн яамны сайдын тушаалын дагуу тусгай хөнгөлөлт гэх мэт давуутай нөхцөл байдлыг эдлүүлж болох тухай Ерөнхий хуулиар заах юм.

3.2. ТЭХ-ийн 16,18 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Одоогийн ТЭХ-ийн 16-р зүйлийн «Улсын татвар» гэдэгт «Хүн амын орлогын албан татвар», «Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар»-ыг хэвээр нь үлдээх хэрэгтэй бөгөөд 18-р зүйлийн «татварын хувь хэмжээг тогтоох» тухай заалтад дээр дурдсан 2 татварын хувьд орон нутгаас нь хамааруулж татварын хувь хэмжээг бууруулах ёсгүй гэж үзэж байна.

Тайлбар

Энэхүү 2 татварыг улсын татвар гэж хэвээр нь үлдээх учир шалтгаан нь бүс нутгийн шинжтэй тэгш бус байдлыг татвар төлөгчдийн дунд төрүүлэхгүй байх үүднээс юм. Жишээлбэл, их хэмжээний татвар төлж үүргээ сайн биелүүлж буй татвар төлөгч орших бүс нутгийн хувьд тухайн нутгийн засаг захиргаа л илүү их орлого олох бөгөөд энэ нь орон нутаг хоорондын ялгаатай байдлыг л даамжруулна. Энэ байдлаас сэргийлэх үүднээс мөн Монгол улсын хөгжил, татварын орлогын өсөлт

нь хуулиар шийдэгдэх асуудал тул дээрх татварын 2 төрлийг улсын төвлөрсөн төсөвт оруулан тооцож, дараа нь орон нутагт хуваарилдаг болгох ёстой.

Мөн эдгээр 3 төрлийн татвар нь улсын татвар тул тухайн орон нутгийн ИТХ-аас эдгээр татварын хувь хэмжээг бууруулах үндэсгүй юм.

3.3 «Татварын маргаан таслах зөвлөл»-тэй холбоотой шинэ заалт оруулах тухай

Одоогийн ТЭХ-д «Татварын маргаан таслах зөвлөл»-тэй холбоотой заалт оруулахын зэрэгцээ тус зөвлөлийн бүрэлдэхүүнд «Хууль зүйн яамнаас эсхүл шүүхээс төлөөлөгч» байлцуулах хэрэгтэй.

Тайлбар

Татвар төлөгчийн эрхийг хамгаалах болон улсын төсвийн орлогыг бүрдүүлэх үүднээс татварын алба татвар төлөгчийн хооронд үүссэн маргааныг аль болохоор удаашруулалгүй түргэн зөв шийдвэрлэх шаардлагатай билээ. Иймээс энэ асуудлыг шийдвэрлэх «Татварын маргаан таслах зөвлөл»-ийн тухай заалтыг зайлшгүй оруулж өгөх нь зүйтэй юм.

Уг зөвлөлийн бүрэлдэхүүн нь татварын маргааныг бодитойгоор шийдвэрлэх чадвартай байх нь зүй ёсны хэрэг юм. Гэсэн хэдий ч тус зөвлөл маргааныг хэрхэн шийдвэрлэснээс үл хамааран уг хэрэг шүүхэд шилжихэд улс заргаа алдах тохиолдол их гардаг тул уг зөвлөлийн бүрэлдэхүүнд анхнаас нь хууль зүйн яамнаас хүн аль эсхүл шүүгч байлцуулснаар уг зөвлөл шийдвэрлэсэн маргааны талаар түүнийг шүүхэд хэлэлцэх шатанд ч оролцох бололцоотой болох юм. Ингэснээр зөвлөлийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагааны агуулгыг оновчтой болгох, татварын албаны үйл ажиллагааны зардлыг бууруулах боломж бүрдэх ба хэрэг шүүхэд хэлэлцэгдэх үед татварын алба заргаа алдах тохиолдол багасах юм. Энэ бүхний үүднээс зөвлөлийн бүрэлдэхүүнд Хууль зүйн яамнаас зохих хүн эсхүл шүүгч байлцуулах хэрэгтэй гэж үзсэн болно.

3.4 ТЭХ-ийн 24 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Одоогийн татварын ерөнхий хуулийн 24-р зүйлийн «татварын алба, татварын байцаагчийн бүрэн эрх»-ийн хувьд

- (1) 24-р зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтыг хасах нь зүйтэй.
- (2) 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт болох «Татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой бүртгэл, тайлан тэнцэл, бусад санхүүгийн бичиг баримтыг шалгаж, тайлбар гаргуулах» гэдгийг дараах маягаар өөрчлөх

«Татварын байцаагч нь өөрийн харъяалагдах татварын албанд хамаарах бүх татвар төлөгчийн хувьд татвар ногдуулалт,

төлөлттэй холбоотой бүртгэл, тайлан тэнцэл, бусад холбогдох санхүүгийн бичиг баримт болон татвар төлөгчийн бүх хөрөнгөнд шалгалт хийж, асуулга явуулж, тайлбар гаргуулан авах бүрэн эрхтэй. Мөн татварын хяналт шалгалтад шаардлагатай нотологоо баримтын хуулбарыг татвар төлөгчөөс үнэ төлбөргүйгээр гаргуулан авах» гэх

- (3) 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын «Татварын хяналт шалгалтанд шаардлагатай нотлох баримт бичгийн хуулбарыг татвар төлөгчийн харилцагч аж ахуйн нэгж, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах» гэдгийг дараах маягаар өөрчлөх

«Татварын байцаагч нь татварын хяналт шалгалтанд шаардлагатай баримтын хуулбарыг татвар төлөгчийн бүх харилцагч хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, улс, орон нутгийн байгууллага, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авна. Мөн тус хуулийн 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан эрхийг тус харилцагчийн хувьд ч мөн адил эдэлнэ.» гэх

- (4) 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын «Хуулийн этгээд» гэдгийг «татвар төлөгч» гэж өөрчлөх.

Тайлбар

- (1) 24-р зүйлийн 1 дэх хэсгийн 10-ын f-ийн заалт нь татвар төлөгч татварын өртэй бөгөөд үүнийгээ хүлээн зөвшөөрч буй хэрнээ төлөхгүй байгаа тохиолдолд татварын алба шүүхэд хандаж (Процессын хуулийн 27-р зүйл) татварын өрийг эцэслэн шийдвэрлэх тухай заасан заалт юм. Татварын ерөнхий хууль нь төсвийн орлогын бүрдэлтийг бусад аливаа хууль тогтоомж, тушаалаас үл хамааран хэвийн байдалд хангах тухай үндсэн санааг тусгасан байх ёстой билээ. Гэтэл татвар төлүүлэхийн тулд шүүхэд хандах тухай өнөөгийн хууль дахь заалт нь татварын хуулинд тавигдах үндсэн нөхцөл болон татварын албаны бүрэн эрхэд харшилж байгаа тул үүнийг хасах хэрэгтэй байна. Үүнийг хассанаар татвар хураалтын ажлын хэрэгжилт илүү сайжрах болно гэж үзэж байна.

- (2) 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт нь татварын байцаагчийн шалгалт явуулах эрхийн талаар заасан заалт бөгөөд энэхүү заалт нь хэвээрээ байх тохиолдолд татварын байцаагчийн татварын үйл ажиллагаа явуулах эрх хэт явцуу жижиг хүрээтэй, татварын албаны үйл ажиллагаа үр дүнтэй явагдахад саад учруулах тул дээрх маягаар өөрчлөх хэрэгтэй байна.

Энэхүү өөрчлөлт нь татварын байцаагчийн асуулга, шалгалт явуулах эрхийг тодорхойлсон заалт бөгөөд татвар ногдуулалт, татвар төлөлттэй холбоотой татвар төлөгчийн зөвхөн санхүүгийн бичиг баримтад шалгалт явуулах бус харин түүний бүх хөрөнгөд ч мөн адил шалгалт явуулах, мөн татвар төлөгчийн энэхүү эрх нь

түүний харъяалах татварын албаны бүх татвар төлөгчийн хувьд хэрэгжих нөхцлийг бүрдүүлж өгч байгаа болно.

- (3) 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт нь татварын байцаагч татварын хяналт шалгалтанд хамрагдаж буй татвар төлөгчийн харилцагч аж ахуйн нэгж, санхүүгийн байгууллагаас татварын хяналт шалгалтанд шаардлагатай баримтын хуулбарыг үнэ төлбөргүй гаргуулан авч болох тухай заасан заалт бөгөөд энэхүү заалт нь энэ хэвээрээ байвал ердөө л холбогдох баримтыг л гаргуулан авах тухай заасан заалт болох тул энэхүү заалтын хамрах хүрээ, хамаарагдах этгээдийг тодорхой болгох үүднээс ийнхүү өөрчлөх хэрэгтэй байна.

Энэхүү өөрчлөлт нь татварын улсын байцаагчид өөрийн харъяалах татвар төлөгчийн бүх харилцагчаас (харъяаллыг үл харгалзан бүх харилцагчаас) баримтын хуулбар үнэ төлбөргүй гаргуулан авч чадахын зэрэгцээ 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт дахь бүрэн эрхээ эдгээр харилцагч татвар төлөгчид хэрэгжүүлэх боломж олгож байгаа юм. Энэхүү өөрчлөлтөөр татварын байцаагчийн явуулах татварын хяналт шалгалт нь татварын ерөнхий хуулийн дагуу зохих журмын дагуу явагдаж байгаа гэдгийг тодорхойлж, мөн татварын хяналт шалгалт илүү үр дүнтэй явагдах боломжийг олгож өгөх болов уу.

- (4) 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт нь зөвхөн аж ахуйн нэгж байгууллагын хувьд бус бүх татвар төлөгчийн хувьд үйлчлэх ёстой заалт болно.

3.5 «ТМНБ», «ТИНБ»-той холбоотой заалт оруулах тухай

Одоогийн ТЕХ-д «ТМНБ», «ТИНБ»-той холбоотой заалт оруулах ёстой байгаа бөгөөд мөн шалгалтанд орох эрхийн хувьд «Монгол улсын ҮТЕГ-ын НББ-ийн 1-р зэрэг олгох шалгалтанд тэнцсэн этгээд»-д шалгалт өгөх эрх олгох хэрэгтэй. Мөн шалгалт өгөх эрх олгохтой холбоотой заалтын хувьд «ҮТЕГ-ын хэлтсийн даргаас дээш болон татварын хэлтэс, дүүргийн татварын газрын даргын албан тушаал хашиж байсан этгээдийн хувьд ямар нэгэн нөхцөлгүйгээр шууд эрх олгох » гэж заах хэрэгтэй байна.

Мөн «ТИНБ»-ын тухай заалтад «Монгол улсын ҮТЕГ-ын НББ-ийн 1 зэрэг олгох шалгалтанд тэнцсэн этгээд»-ийн тухайд зарим нэг шалгалтаас чөлөөлөх болон шалгалт өгөх эрх олгох гэсэн давуутай нөхцөл байдал олгож өгөх хэрэгтэй байна.

Тайлбар

«ТМНБ», «ТИНБ»-той холбоотой заалтыг оруулах нь татварын албаны ажилтны хувьд түүнийг ажлаас гарсны дараах эдийн засгийн болон нийгмийн баталгааг бий болгосноор одоо ажиллаж буй

ажилтны ажиллах урам зоригийг дээшлүүлж, татварын хяналтыг татвар төлөгч болон татварын албанаас хамааралгүй бие даан явуулах боломж бүрдэх бөгөөд ингэснээр тайлан тушаалт болон түүний чанарын төвшинг дээшлүүлэхэд ихээхэн хувь нэмэр болох нь тодорхой тул үүнийг нягтлан авч үзэх хэрэгтэй байна.

Шалгалт өгөх эрхийн асуудлын хувьд бакалавраас дээш зэрэгтэй гэж хязгаарлалт тогтоох бус, мэргэжил сонгох эрх чөлөө, боломж нөхцлийг хангаж өгөх үүднээс, мөн тэргүүний ТМНБ, ТИНБ-дыг олноор төрүүлэн гаргах үүднээс Монгол улсын нийгэмд НББ-ийн үйл ажиллагааг чанарын хувьд дээшлүүлэхийн тулд яах аргагүй бий болгох ёстой «Монгол улсын ҮТЕГ-ын НББ-ийн 1-р зэрэг олгох шалгалтанд тэнцсэн этгээд»-д ч бас шалгалт өгөх эрх олгох, эсхүл зарим нэг шалгалтаас чөлөөлөх, шалгалтаас бүрэн чөлөөлөх зэрэг давуу нөхцлийг олгох хэрэгтэй.

Мөн ҮТЕГ-ын хэлтсийн даргаас дээш албан тушаал, татварын хэлтэс, дүүргийн татварын газрын даргын албан тушаал хашиж байсан этгээдийн хувьд хэдийгээр түүний ажилласан хугацаа богино байлаа ч тухайн ажил албан тушаалын чухал байр суурь, хариуцлагыг харгалзан үзвэл авилгал авсан, татвартай холбоотой асуудлаар хуулийн хариуцлага хүлээж байсан, эрх авсны дараа хуулийн хариуцлага хүлээж байсан тохиолдлоос бусад нөхцөлд түүнд ямар нэгэн нөхцөлгүйгээр шууд эрх олгох ёстой билээ.

Бүлэг 4

4. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль (Процессийн хууль)-ийн өөрчлөлттэй холбогдох санал

Дор дурдсан зүйл ангиудад өөрчлөлт оруулах хэрэгтэй бөгөөд ялангуяа 4.1, 4.5, 4.8, 4.9, 4.16 хэсгийн заалтыг нэн даруй өөрчлөх шаардлагатай.

4.1 Процессийн хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Хуулийн «Татвар төлөгчийг бүртгэх» тухай 5 дугаар зүйлд дараах өөрчлөлт оруулах нь зүйтэй. Үүнд:

- (1) Тус хуулийн 5-р зүйлийн 3 болон 4 дэх заалтыг дараах маягаар өөрчлөх

«Татварын алба нь иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон татвар суутган авагч этгээдийг татварын төрөл тус бүрээр бүртгэн, татвар төлөгч бүрд нэг регистрийн дугаар олгож, хувийн хэрэг нээнэ. Татвар төлөгчид хувийн хэрэгт хавсаргах дараах зүйлсийг тусгасан баримт материалыг бүрдүүлнэ.

- 1) Татвар төлөгчийн регистр гэрчилгээний дугаар, удирдлагын овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар
- 2) Татвар төлөгчийн оршин суугаа хаяг, гишүүд ажилчдын тоо, утасны дугаар, удирдлагын гишүүдийн товч анкет, зураг, иргэний үнэмлэхийн дугаар
- 3) Аж ахуйн нэгжийн байгуулагдсан он сар өдөр, үйл ажиллагааны чиглэл хэлбэр
- 4) Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, газар эзэмшлийн байдал, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө зэргийг тусгасан баталгаажсан тайлангийн хуулбар
- 5) Хөрөнгө оруулагчид болон харьяа салбар нэгжийн нэр, тоо, тэдгээрийн байршил, хаяг утас
- 6) Санхүүгийн удирдлага зохион байгуулалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалт, татварын тайлан гаргадаг ТИНБ-ийн овог нэр, хаяг, утас
- 7) Гэрээт татварын мэргэжсэн нягтлан бодогчийн овог нэр, хаяг, утас
- 8) Дүрмийн сангийн хэмжээ, түүний өссөн буурсан байдал, гол харилцагч газруудын нэр, хаяг
- 9) Татвар төлөгчийн төлөх татварын төрөл, банкин дахь дансны дугаар

Тайлбар

Хуулийн 5-р зүйлийн 3 болон 4 дэх хэсэг нь татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэх тухай заасан заалт бөгөөд энэхүү

өөрчлөлтөөр татвар суутган авагч этгээдийн хувьд ч бүртгүүлэхэд шаардагдах материалыг зүйлийг мөн адил тогтоож өгөх шаардлагатай байна. Мөн хуульд заасан бүртгэлийн зүйлүүд нь бүртгэл явуулсны дараа тухайн татвар төлөгчийг хянахад хангалттай бус тул дээрх үзүүлэлтүүдээр татвар төлөгчийг бүртгэх хэрэгтэй гэж үзэж байна. Мөн нэг татвар төлөгчийг хэд хэдэн татварын төрлөөр бүртгэх тохиолдолд, жишээ нь ААНБОАТ, НӨАТ, үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгч болсон татвар төлөгчийн регистрийн дугаар нь тухайн тэр татварын төрлүүд дээр нэгдсэн нэг байхаар бодолцсон болно.

- (2) Хуулийн 5-р зүйлийн 5 дахь хэсэг болох «Татвар төлөгч нь бүртгэлд тусгагдсан зүйл өөрчлөгдөх тухай бүр хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрчлөлт орсноос хойш 1 сарын дотор татварын албанд мэдэгдэж, бүртгэлд өөрчлөлт хийлгэнэ.» гэдгийг дараах байдлаар өөрчлөх

«Татвар төлөгч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх тухай бүрд хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрчлөлт орсноос хойш 1 сарын дотор энэ тухайгаа татварын албанд мэдэгдэж, бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэнэ. »

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь зохих хэмжээнд татвар төлөгчийн ажил, үйлчилгээг хянах, татварын хяналт шалгалт, татвар хураалтын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой бөгөөд татвар төлөгчийн хувийн хэрэгт орсон аливаа өөрчлөлтийг татварын албанд мэдэгдэж байхыг татвар төлөгчид үүрэг болгосон хэрэг юм.

- (3) Тус хуулийн 5-р зүйлийн 5 дахь хэсгийн ард дараах зүйлийг нэмж оруулах

«Үл хөдлөх хөрөнгийг бусдад худалдах, худалдан авах, шилжүүлэх, бэлэглэх болон түүнээс бусад хэлбэрээр шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд татвар төлөгч нь харьяалагдах татварын албанд энэ тухайгаа 20 хоногийн дотор мэдэгдэнэ.»

Тайлбар

Энэхүү шинэ заалтаар татвар төлөгчийн үл хөдлөх хөрөнгөд шилжилт хөдөлгөөн гарсан тохиолдолд 5-р зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас богино хугацаанд 20 хоногийн дотор татварын албанд энэ тухайгаа мэдэгдэх асуудлыг хуульчлах хэрэгтэй гэж үзсэн. Энэ нь өндөр үнэ хүрдэг, татвар төлөгчийн хувьд чухал хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг татварын алба тухай бүр нь мэдэж байх шаардлагатай холбоотой болно.

- (4) Тус хуулийн 5-р зүйлийн 6 болон 7 дахь хэсгийг нэгтгэж, дараах байдлаар өөрчлөх

«Татварын төрлөөр олгосон регистрийн дугаарыг татвар төлөгч, татвар суутган авагч аливаа этгээд татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн болон бусад шаардлагатай баримтуудад бичнэ. Татвар төлөгч нь байнгын регистрийн дугаараа өөрийн харилцагчид мэдээлж байх үүрэгтэй. Мөн татвар суутган авагч этгээдэд бүртгэлийн дугаар олгох журмыг ҮТЕГ батална.»

Тайлбар

Энэхүү өөрчлөлтөөр татварын албаны зүгээс татвар төлөгчид хяналт тавих үүднээс ҮТЕГ-ын зүгээс нэвтрүүлэхээр төлөвлөж буй кассын машины системд тулгуурлан нэг татвар төлөгчид олгох нэг регистрийн дугаарыг нэгдсэн нэг бодит дугаар болгож, татвар төлөгч өөрийн татварын холбогдолтой аливаа баримт бичиг болон өөрийн харилцагчид өгөх аливаа баримтад тэмдэглэж байхыг аливаа татвар төлөгч болон татвар суутган авагч этгээдэд үүрэг болгосон болно.

- (5) Хуулийн 5-р зүйлийн 8 дахь хэсгийг хүчингүй болгож, дараах өөрчлөлт оруулах

«Аливаа татвар төлөгч нь харилцагч татварын байгууллагаа солихдоо тухайн төсвийн жил дууссаны дараа ямар нэгэн татварын өргүй тохиолдолд хийж болно. Татвар төлөгч татварын өртэй бол түүний шилжилт хөдөлгөөнийг хийхгүй бөгөөд шилжилт хийлгэх татвар төлөгч нь өөрийн хувийн хэрэг болон орлого татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийлгэж, зохих татварын тооцоог хийж барагдуулна.»

Тайлбар

Татвар төлөгчийн дугаарыг бүртгүүлэх үүргийн талаар тус зүйлд заасан бөгөөд түүнтэй холбоотой нарийвчилсан журмыг татварын албаны удирдах дээд байгууллага гаргах нь зүйн хэрэг тул процессын хуулийн 5-р зүйлийн 8 дахь хэсгийг хүчингүй болгох нь зүйтэй. Мөн шинэ заалтаар татвар төлөгчийн татварын албаны харъяаллын өөрчлөлт хөдөлгөөн тодорхой бус байсныг тодорхой зааж өгсөн болно.

4.2 Процессийн хуулийн 7 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Тус хуулийн 7-р зүйлийн «Татварын алба, татварын байцаагчийн татвар төлөгчтэй харьцахад үйлдэх баримт бичиг»-т дараах өөрчлөлт оруулах

1. Хуулийн 7-р зүйлийн 5 дахь хэсэг дэх «тогтмол дүн»-г «жишиг дүн» гэж өөрчлөх

2. Хуулийн 7-р зүйлийн 6 дахь хэсэг дэх «ахуйн нэгж, байгууллага» гэдгийг «Татвар суутган авагч этгээд» гэх

Тайлбар

1. Энэ заалт нь татвар төлөгч хуульд заасан хугацаанд татвараа төлөөгүй тохиолдолд мөн жишиг дүнгээр татвар ногдуулах тохиолдолд татварын байцаагч мэдэгдэл бичих тухай заалт бөгөөд хоёрдахь тохиолдолд нь «тогтмол дүн» гэснээс «жишиг дүн» гэж татвар төлөгч тус бүрийн онцлогт тохируулан татвар ногдуулах нь оновчтой болох учраас «жишиг дүн» гэж өөрчлөв.
2. Тус хуулийн энэхүү хэсэгт зөвхөн аливаа аж ахуйн нэгж, байгууллага бус хувь хүн тэргүүтэй аливаа татвар суутган авагч этгээд ч мөн хамаарах тул ийнхүү өөрчилсөн болно.

4.3 Процессийн хуулийн 14 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Хуулийн 14-р зүйлийн «Ажлын зураг авалт хийх журам»-ын 1 дэх хэсэг болон түүний 1 дэх дугаарын заалтыг дараах маягаар өөрчлөх

Тус хуулийн «Татварын байцаагч нь татварын ерөнхий хуулийн 24-р зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын хүрээнд ажлын зураг авалт хийхдээ дараах журмыг баримтална. Татвар төлөгчийн зөвхөн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалт хийнэ.» гэдгийг «Татварын байцаагч нь ажлын зураг авалтыг татварын ерөнхий хуулийн 31-р зүйл болон тус хуулиар тогтоосон эрхийн хүрээнд дараах журмын дагуу явуулна. Татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалт хийнэ.» гэх

Тайлбар

Одоогийн заалт нь татвар төлөгчийн төлөх ёстой татварын хэмжээг л тогтоох зорилгоор ажлын зураг авалт хийх тухай заасан нь түүний хамрах хүрээг явцуу болгож байна гэж хэлж болохоор байна. Иймээс татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг тогтоохын тулд татвар төлөгчийн үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, зардал зэргийг ч бас ажлын зураг авалтад хамруулсан болно.

4.4 Процессийн хуулийн 16 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Тус хуулийн 16-р зүйлийн «Татварын ногдлыг бүртгэх» доторх «хууль тогтоомж» гэдгийн ард «болон татварын албаны удирдах дээд байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан заавар, журам, аргачлал, зөвлөмж» гэж нэмэх

Тайлбар

Энэхүү заалт нь татварын албанаас татвар төлөгчийн хувьд бүртгэн авах зүйл болон баримтлах эрх зүйн актуудыг заасан заалт бөгөөд мэдээж энэ үед дагаж мөрдөх эрх зүйн акт нь зөвхөн хууль тогтоомж бус, татварын албаны удирдах дээд байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан заавар, журам, аргачлал зөвлөмж ч бас хамаарахыг тодорхойлж заасан болно.

4.5 Процессийн хуулийн 17 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Тус хуулийн 17-р зүйлийн «Татварын ногдлыг жишгээр тооцох» гэдгийг дараах маягаар өөрчлөх

Одоогийн заалт нь

- «1. Үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа болон явуулж байсан нь нотлогдсон боловч үйл ажиллагааныхаа баримтыг бүрдүүлээгүй, бүртгэл хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн, эсхүл баримт бүртгэл, татварын тайланг гаргаж өгөөгүй тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын ногдлыг татварын алба жишгээр тогтооно.
2. Татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйлдвэрлэл үйлчилгээг тухайн орон нутагт эрхэлж буй татвар төлөгч байгаа бол түүний, байхгүй бол ойролцоо орон нутагт орших хэд хэдэн татвар төлөгчийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн ногдох татварын хэмжээг тогтоохыг татварын ногдлыг жишгээр тодорхойлох гэнэ. Уг татвар төлөгч нь тухайн үйлдвэрлэл үйлчилгээг татвар ногдуулах хугацаанаас өмнөх дараалсан 2 жилд явуулж байсан бол түүний тийнхүү үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байсантай холбогдох баримт бүртгэл тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлж болно.
- 3 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох татварын улсын байцаагчийг томилох, уг татварын хэмжээг тогтоох асуудлыг тухайн татварын албаны даргын тушаалаар шийдвэрлэнэ.»

Өөрчлөлт

- «1 Ашгийн төлөө аливаа үйлдвэрлэл, ажил үйлчилгээ явуулж байгаа болон явуулж байсан нь нотлогдсон боловч үйл ажиллагааныхаа баримтыг бүрдүүлээгүй, бүртгэл хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн, эсхүл баримт бүртгэл, татварын тайланг гаргаж өгөөгүй тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын ногдлыг Татварын албаны даргын шийдвэрийн дагуу жишгээр тодорхойлж баталгаажуулна.
- 2 Татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйлдвэрлэл үйлчилгээг тухай орон нутагт эрхэлж буй татвар төлөгчийн үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлж, жишгээр татвар ногдуулах тохиолдолд тухайн татвар төлөгч нь өөрт байгаа баримт, тэмдэглэл, гар ноорог зэргийг гаргаж өгөх үүрэгтэй.